



Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах

2024 ОНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм



Мэндчилгээ

- 3 Тэргүүн зөвлөлийн захиас
- 4 Бусдыг халамжлах бидний үүрэг
- 5 Орон нутгийнхаа хэн нэгэнд үйлчлэх
- 6 Хүүхэд, эмэгтэйчүүдийг халамжлах
- 8 Сүмийн гишүүдийн бодит үйлдэл
- 10 Бусдад үйлчилж буй номлогчид
- 12 JustServe

ДЭЛХИЙ ДАЯАР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, САНААЧИЛГА

- 16 Үйл ажиллагааны хураангуй тайлан
- 18 Яаралтай тусламж
- 20 Цэвэр ус ба бохирын систем
- 21 Боловсрол
- 22 Хөдөлмөр эрхлэлт
- 24 Байгаль орчныг хамгаалах
- 25 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба хөдөлгөөний бэрхшээл
- 26 Өлсгөлөнтэй тэмцэх
- 28 Орон байрны дэмжлэг
- 29 Сэтгэцийн эрүүл мэнд
- 30 Бие даах чадвар

ДЭЛХИЙ ДАЯАР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

- 34 Африк
- 36 Ази
- 38 Австрали, Филиппин, Номхон далайн бүс нутаг
- 39 Карибын тэнгисийн орнууд
- 40 Төв ба Өмнөд Америк
- 42 Европ
- 43 Ойрх Дорнод
- 44 Хойд Америк

ТАНД БАЯРЛАЛАА

ЭХ СУРВАЛЖ

Нүүр хуудас (цагийн зүүний дагуу дээрээс доош): Хэлэн хар салхины сүйрлийн дараа хоёр эмэгтэй тэврэлдэж байгаа нь. Хондурасын оюутнууд завсарлагаагаар хоол идэж байгаа нь. Гэрэл зургийг Оскар Лэвиа/Католик тусламжийн үйлчлэл (Catholic Relief Services)-ийн Силвэрлайт (Silverlight) хөтөлбөр. Либерийн тариачин будаагаа цайруулж байгаа нь. Японд амьдардаг эмэгтэй ногоогоо хурааж байгаа нь. Угандад моторт цооног нээгдсэний дараа шинэ цоргыг хэрхэн ажиллуулдгийг харуулж буй эмэгтэйчүүд. Ватэр-Эйд (WaterAid)-ийн гэрэл зураг. Мадагаскарт амьдардаг эмэгтэй эрүүл мэндийн үзлэгт орж байгаа нь.

Эрхэм хүндэт найзууд аа,

Бид 2024 онд та бүхнийг цаг заваа харамгүй зориулж, нөөцөө өгөөмрөөр хандивласанд гүнээ талархаж байна. Өнгөрсөн жил Сүмийн гишүүд, найз нөхдийг Есүс Христийн сургаалт зүйрлэлүүддээ заасанчлан мөн Өөрийн мөнх бус амьдрал дахь тохинууллаар харуулсанчлан “хэн нэгэн” рүү гараа сунгахад урьсан.

Таны энэхүү урилгыг чин сэтгэлээсээ хүлээн авсан явдал биднийг үнэхээр даруусгаж байна. Та бүхэн дэлхий даяар хэн нэгэн хүнд гараа сунгаж, хөршөө хайрласнаар уг урилгын дагуу үйлдсэн билээ. Бид та нарын оруулсан хувь нэмэрт талархахын сацуу энэ жилийн хамтын хүчин чармайлтынхаа тайланг хуваалцаж байгаадаа баяртай байна. Бид яаралтай тусламж үзүүлэх, өлсгөлөнтэй тэмцэх, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн сайн сайхан байдалд санаа тавих зэрэг санаачилгуудаар дамжуулан Бурханы хүүхдүүдийг хэрхэн хамтдаа халамжилсан тухай энэхүү хураангуй тайланд тусгана. Энэхүү хүчин зүтгэл нь та бүхний өгөөмөр сэтгэлийн ачаар боломжтой болж, итгэл хүлээсэн байгууллагуудын хамтын ажиллагаагаар хэрэгжиж, хаа сайгүй тусламж хэрэгтэй байгаа хөршүүддээ анхаарал халамж тавихыг хичээж буй хүмүүсийн сайхан сэтгэлийн ачаар өргөжин тэлж байгаа билээ.

Бид Бурханы хүүхдүүдийг үргэлжлүүлэн халамжилснаар тэдэнд Түүний бурханлаг хайрыг мэдрэхэд тусалж чадна. Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхэд нэг бүрийг хайрладаг бөгөөд тэдний сайн үйлсийг мэддэг. Бид та бүхнийг эргэн тойрныхоо хүмүүст үргэлжлүүлэн үйлчилж, тэднийг хайрлахыг урьж байна. Бурхан та бүхний сүнслэг үйл хэргийг адислах болтугай.

Тэргүүн зөвлөл

Russell M. Nelson

Dallin H. Oaks

Henry B. Eyring

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон өөрийн хоёр зөвлөх болох ерөнхийлөгч Даллин Х.Өүкс, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг нарын хамтаар Навахо үндэстний ерөнхийлөгч Бүү Нигрэн, тэргүүн хатагтай Жасмин Блэкватэр-Нигрэн хоёртой мэндчилж байгаа нь.





Тонга дахь Халамжийн нийгэмлэгийн эгч нар орон нутгийнхаа тусламж хэрэгтэй байгаа хүмүүст зориулан хоол хийж байгаа нь.

Бусдыг халамжлах бидний үүрэг

Христ мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үеэр бидэнд Бурханыг болон хөршөө хайрлах эхний ба хоёр дахь агуу зарлигийг өгсөн. Түүнчлэн Тэрээр “сайныг үйлдэж явсан” (Үйлс 10:38) ба тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах гэдэг нь чухамдаа ямар утга учиртайг бидэнд харуулсан юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Аврагчийн хайр, үйлчлэлийн үлгэр жишээг дагахыг хичээдэг. Сүмийн албан ёсны халамжийн хөтөлбөрийг 1936 онд зарласан бөгөөд тусламж хэрэгтэй гишүүдийг халамжилж, бие даах чадварыг нь бэхжүүлэх зорилгоор байгуулагдсан аж. 1984 онд Сүм халамжийн үйл ажиллагаагаа дэлхий даяарх сая сая хүнд хүртээмжтэй болгохоор хүмүүнлэгийн ажлаа эхлүүлсэн билээ.

Өдгөө Сүм халамжийн болон бие даах чадвар хөгжүүлэх санаачилга, дэлхий даяарх хүмүүнлэгийн ажил, сайн дурын үйлчлэл зэргээр дамжуулан гишүүдийн төдийгүй тусламж хэрэгтэй бусад хүний аль алиныг халамжлахаар хичээнгүйлэн чармайсаар байна.

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд болон уг Сүмийн гишүүд болох бидэнд бусдадаа үзүүлэх халамж, хүмүүнлэгийн үйлчлэлийн талаар байнга заадаг бөгөөд үүнийг бодитоор хэрэгжүүлдэг.”

—Даллин х.ӨҮКС, тэргүүн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх¹

Хүмүүнлэгийн ажил

Сүм арьс өнгө, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэгээс үл хамааран тусламж хэрэгтэй хүмүүст туслах олон мянган хүмүүнлэгийн төслийг дэмждэг.

Халамжийн болон бие даах чадвар хөгжүүлэх санаачилга

Халамжийн болон бие даах чадвар хөгжүүлэх ажил нь юуны түрүүнд Сүмийн гишүүдэд ач тусаа өгдөг ба үүнд мацгийн өргөлийн тусламж, бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүд, сэтгэцийн болон сэтгэл санааны эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, боловсролын хөтөлбөрүүд багтдаг.

Сайн дурын үйлчлэл

Сайн дурын үйлчлэл бол бидний хүмүүнлэгийн болон халамжийн ажил, бие даах чадвар хөгжүүлэх хүчин чармайлтын үндэс суурь юм. Энэ нь гишүүд, номлогчид болон Сүмийн найз нөхдийн үүрэг амлалт, хичээл зүтгэлээр боломжтой болдог. Эдгээр сайн дурын ажилд олон нийтэд үйлчлэх төслүүд, гамшгийн үеийн цэвэрлэгээ, Сүмийн халамж болон бие даах чадвар хөгжүүлэх төвийн номлолын ажил ордог.



Орон нутгийнхаа хэн нэгэнд үйлчлэх

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон 2024 оны 9-р сард 100 насныхаа ойг тохиолдуулан, Христийн алдагдсан хонины сургаалт зүйрлэлд дурдсанчлан хэн нэгэн хүнд хүрч үйлчлэхийг бид бүгдээс хүссэн билээ. Уг сургаалт зүйрлэлд халамжит хоньчин тусламж хэрэгтэй нэг хонио олохоор аглаг буйд руу явсан нь биднийг Аврагчид ямар их үнэ цэнтэйг сануулдаг.

Дэлхий даяарх гишүүд гэр бүлийн гишүүн, найз, хөрш зэрэг орон нутгийнхаа хэн нэгэнд үйлчлэхээр энэхүү урилгыг баяртай хүлээн авсан юм. Ерөнхийлөгч Нэлсон энэ талаар ийм удирдамж өгчээ. “Ирэх саруудад би та бүхнийг залбиралтайгаар: Урам хугарсан хэнийг би мэдэх билээ? Би хэнтэй учраа олж, уучлал гуйх хэрэгтэй байгаа билээ? Яагаад гэдгийг мэдэхгүй ч нэр нь миний санаанд орж ирээд байгаа хэн байгаа билээ? гэсэн асуултуудыг бодож үзэхийг урьж байна. Та бүхэн Их Эзэнд хандан эдгээр асуултаа тавих юм бол, Тэрээр таныг тусламж хэрэгтэй байгаа тэр нэг хүнд хэрхэн хүрч, дэмжихээ мэдэхэд тань нөлөөлөх болно.”



Орон нутагтаа тусламж хэрэгтэй хэн нэгэнд үйлчлэхэд тань туслах дараах санаануудыг бодож үзнэ үү.

- ◆ **Найзтайгаа уулзах:** Таны нөхөрлөл хэрэгтэй байгаа хэн нэгэнтэй холбоо барь. Тэдэнтэй уулзаж ярилцан, үдийн хоол идэх юм уу хамт алхах цаг гарга.
- ◆ **Хоол хийх:** Хэн нэгнийг оройн хоолонд урь эсвэл тусламж хэрэгтэй хэн нэг хүнд хоол аваачиж өг.
- ◆ **Хүүхэд, өсвөр насныханд зөвлөх:** Нэг хүүхдээс ном уншиж өгөөч гэж хүс, эсвэл гэрийн даалгавраа хийхэд нь түүнд тусал эсвэл хамт шалгалтад нь бэлд.
- ◆ **Хувцас, хоол хүнс, бусад зүйлийг хандивлах:** Орон нутгийнхаа хандивын аян, түр хоргодох байр, энэрлийн байгууллагад хэрэгцээтэй зүйлсийг өг.
- ◆ **Гэр бүлдээ туслах:** Аяга тавгаа угаа, өрөөгөө цэвэрлэхэд нь ах, эгч, дүүдээ тусал эсвэл гэр бүлийн гишүүнээ тэвэр.
- ◆ **Сонсох:** Гэр бүлийн гишүүн, найз эсвэл хөрштэйгөө хамт суугаад, зүгээр л юу хэлэхийг нь сонс. Сонсох нь анхаарал халамж тавьж байгаагаа харуулах, тэдэнд хэрхэн үйлчлэхээ ойлгох боломжийг өгдөг.
- ◆ **Зурвас эсвэл тэмдэглэл илгээх:** Хэн нэгэнд энгийн зурвас илгээ эсвэл найрсаг захидал бичиж, анхаарч халамжилдгаа мэдрүүл.
- ◆ **Баярлалаа гэж хэлэх:** Найз нөхөд, гэр бүлийнхэн, тэр ч байтугай шуудан хүргэгч гэх мэт өдөр бүр танд тусалдаг хүмүүст талархлын зурвас үлдээ.
- ◆ **Орон нутгийнхаа Сүмийн удирдлагатай ярилцах:** Халамжийн нийгэмлэг эсвэл ахлагчийн чуулгын ерөнхийлөгчөөс орон нутагт тань тусламж хэрэгтэй байгаа хүн байгаа эсэхийг асуу.
- ◆ **Удирдамж гуйн залбирах:** Тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах хичээл зүтгэлийг тань чиглүүлж, сүнслэгээр нөлөөлөхийг Бурханаас гуй.
- ◆ **JustServe.org-оос үйлчлэх боломжуудыг хайж олох:** Justserve.org руу зочлох эсвэл аппликэйшныг нь татаж аван өөрт ойролцоо орших үйлчлэлийн төслүүдийг хай.





Филиппиний хүүхдүүд сургууль дээрээ Босож дахин барьцгаая сан (Rise and Rebuild Foundation)-ийн үндэслэн байгуулсан шим тэжээлтэй үдийн хоолыг идэж байгаа нь.

Хүүхэд, эмэгтэйчүүдийг халамжлах

2024 онд Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл Сүмийн хийгээд нийгмийн хүрээнд эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх дэлхий дахины санаачилгыг өргөжүүлж буйгаа зарласан. Энэхүү санаачилга нь хүүхдийн хоол тэжээл болон эх, нярайн асаргаанд мөн дархлаажуулалт болон боловсролд төвлөрдөг.

Ерөнхийлөгч Камилл Н.Жонсон: “Дэлхий дахины хөгжил дэвшил нь хүүхдүүдийг асран халамжилж, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхээс эхэлдэг. Та нэг эмэгтэйд адислахад түүний гэр бүл, нийгэм, улс үндэстнийг бас адисалдаг. Үүнтэй адил та нэг хүүхдийг адисалснаар ирээдүйдээ хөрөнгө оруулж байдаг” хэмээн онцолсон.

Сүмийн гишүүд гэр бүлдээ болон эргэн тойрныхоо хүмүүст анхаарал халамж тавьснаар энэхүү ажилд өдөр бүр хувь нэмрээ оруулдаг. **Энэхүү санаачилгад хэрхэн оролцох талаар санаа авахыг хүсвэл хуудасны доод хэсэгт байрлах QR кодыг уншуулна уу.**

Хүүхдийн хоол тэжээл

Дэлхий даяар 148 сая орчим хүүхэд хоол тэжээлийн архаг дутагдалтай байна. Таваас доош насны хүүхдүүдийг эрүүл хоол хүнсээр хангах нь тэдний тархины зөв хөгжил болон дархлаанд мөн бүрэн өсөж торниход нь нэн чухал байдаг.

Сүм даяарх хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдалтай тэмцэхийн тулд Сүм хүүхдийн хүнс тэжээл, эрүүл мэндэд төвлөрсөн санаачилгыг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр нь таваас доош насны хүүхдүүд болон тэдний эцэг эхийг хүнс тэжээлийн дутагдлыг илрүүлж, шийдвэрлэхэд шаардлагатай эх сурвалжуудаар хангадаг билээ.

Сүм түүнчлэн ашгийн бус байгууллагуудтай хамтран Сүмээс гадуурх хүүхдүүдэд зориулсан эрүүл мэнд, хоол

тэжээлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, хяналт тавьж ажилладаг. Сүм Филиппин дэх Каритас Манила (Caritas Manila) ашгийн бус байгууллагад хүүхдийн хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэхэд туслах нэмэлт хоол, витамин, эрүүл ахуйн хэрэгслээр хангах ажилд нь тусалж хандив өргөжээ.

Эх, нярайн асаргаа

Төрөхийн өмнөх болон төрсний дараах асаргаа нь эх, нярайн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад тусалдаг. Сүм эмч мэргэжилтнүүд, эмнэлгийн байгууллагуудыг шаардлагатай сургалт, тоног төхөөрөмжөөр хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүмийн олгосон хандиваар дамжуулан Хөүп (HOPE) төсөл нь Колумб, Венесуэл зэрэг улсад эх, нярайн асаргааны талаар сургалт явуулж, тоног төхөөрөмж олгож, эхийн эндэгдлийг ихээхэн бууруулсан байна. Түүнээс гадна, иргэдийн мөргөлдөөний улмаас Либерийн эмнэлгийн барилга байгууламж нурж, тоног төхөөрөмж нь сүйдсэний дараа Сүм төрөх эмнэлгийн шинэ байр болон иж бүрэн тоноглол бүхий нярайн тасгийг барихад хандив өргөв.

Дархлаажуулалт

Дархлаажуулалт нь эх, нярайг эндэхэд хүргэдэг өвчнүүдээс эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хамгаалахад нэн чухал юм. Сүм эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд эмзэг бүс нутгуудад вакцин түгээхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилладаг. Сүм НҮБ-ийн Хүүхдийн санд хандив өргөсний ачаар Мали улс дахь эмэгтэйчүүд нярайн татрангийн эсрэг вакцин хийлгэж, улмаар амь насанд аюултай энэ өвчин тус улсад байхгүй болжээ.



Боловсрол

Чанартай боловсрол нь хувь хүний бие даах чадварыг нэмэгдүүлдэг. Иймээс Сүмийн гишүүнчлэлээс үл хамааран хүүхдүүдийг боловсролын нэн чухал эх сурвалжуудаар хангахад Сүм хөрөнгө оруулсаар байна. Сүм Бүгд Найрамдах Конго Улс, Кени, Судан, Уганда улсууд дахь “Амьдралын төлөө суралцах” хөтөлбөрийг дэмжих зорилгоор НҮБ-ийн Хүүхдийн санд санхүүжилт олгожээ. Энэ хөтөлбөр нь эмзэг бүлгийн 140,000 орчим хүүхдэд бага насны хүүхдийн хөгжил, боловсролын чанартай үйлчилгээг олгож байна.

Энэхүү дэлхий дахины санаачилга нь хүүхдүүдийг боловсролтой болгоод зогсохгүй эмэгтэйчүүдийг бие даах чадвартай болоход дэмжлэг үзүүлж, гэр бүл, нийгмийг бэхжүүлдэг. Сүм Словак улсад эмэгтэйчүүдийг цалинтай асрагчид болоход нь сургадаг орон нутгийн нэг байгууллагад хандив өгчээ. Түүнээс гадна уг эмэгтэйчүүдэд мэргэжлийн гэрчилгээтэй болж, ажилд ороход нь шаардлагатай тоног төхөөрөмж, сурах бичиг, дүрэмт хувцас олгож, гэр бүлээ тэжээх боломжтой болгосон байна.

“Хүнс тэжээлийн хямд өртөгтэй, туршигдсан үйлчилгээг өргөжүүлэх нь дэлхий даяарх эхчүүд, хүүхдүүдийн амьдралыг өөрчлөхөд нэн чухал юм. [Бидний Сүмтэй байгуулсан хамтын ажиллагаа] хүүхэд бүрийг эрүүл саруул өсөх боломж олгох урт хугацаанд үргэлжлэх өөрчлөлтийг бий болгоход нийгэмд туслах болно.”

—САРА БУШИ, ХЭЛЭН КЭЛЛЭР ИНТЕРНЭШНЛ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Зүүн талд: Сьерра Леонд вакцин хийлгэж буй хүүхэд. **Баруун талд:** Мадагаскарт амьдардаг эмэгтэй эрүүл мэндийн үзлэгт орж байгаа нь.





Зүүн талд: Сайн дурынхан 2024 оны БЯИС-ийн Эмэгтэйчүүдийн чуулган дээр Өлсгөлөнтэй тэмцье (Hunger Fight) байгууллагад зориулан хоол хүнс баглаж байна. **Баруун талд:** Шинэ Зеланд дахь Сүмийн нэг гишүүн хөршүүддээ үйлчлэх үйлчлэлийн төсөлд оролцож байна.

Сүмийн гишүүдийн бодит үйлдэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бусдад үйлчлэхдээ Аврагчийн үлгэр жишээг дагадаг. Сүмийн гишүүд Бурханыг болон хөршөө хайрлах амлалтынхаа дагуу хүмүүнлэгийн ажилд хандив өргөх, оршин суугаа газрынхаа бусад хүнд үйлчлэх зэрэг замаар тусламж хэрэгтэй хүмүүсийг идэвхийлэн халамжилдаг.

Мацгийн өргөл

Сүмийн гишүүд ойр ойрхон мацаг барьж, “хүн бүр байгаагийнхаа хэрээр ядуустай хөрөнгөө хуваалц” (Мозай 4:26) гэсэн Есүс Христийн зөвлөгөөг дагадаг. Хожмын үеийн гэгээнтнүүд сар бүрийн нэг өдөр мацаг барьж, идээгүй алгассан хоолныхоо мөнгийг тусламж хэрэгтэй бусад гишүүнд туслахын тулд өгөөмрөөр хандивласнаар ийн үйлддэг. Эдгээр хандивыг “мацгийн өргөл” гэж нэрлэдэг. Үүнээс гадна Сүмийн гишүүд бусдын сайн сайхны төлөө цаг зав, авьяас чадвар, энэрэнгүй сэтгэлээ зориулдаг билээ. Орон нутгийн удирдагчид эдгээр өргөлийг ашиглан хувь хүн, гэр бүлүүдэд хэрэгцээгээ хангахад нь тусалдаг юм.

Нэг хүнд үйлчлэх

2024 онд дэлхий даяарх хожмын үеийн гэгээнтнүүд өөрсдийн амьдрал дахь “алдагдсан эсвэл ганцаардсан ‘нэг хүнд’ туслах” ерөнхийлөгч Нэлсоны уриалгыг баяртайгаар хүлээн авсан билээ. Гишүүд тоолшгүй олон сайн үйл, үйлчлэлээрээ дамжуулан дэлхий даяарх Бурханы хүүхдүүдэд Түүний хайрыг түгээдэг.

Юта мужийн Лэйтон хотод нэгэн залуу эмэгтэй ээжтэйгээ хамт цэцэрлэгтээ том суулгацууд суулгахаар худалдан авчээ. Охин нь хөлөө хүнд гэмтээсний улмаас ээж

“Бие биедээ хайртай байваас та нарыг Миний шавь гэдгийг үүгээр чинь бүгд мэдэх болно гэлээ.”

—ИОХАН 13:35

нь суулгацуудыг ганцаараа суулгаж чадахгүй болов. Тэр эмэгтэй ээжтэйгээ хамт ахлагчийн чуулгын ерөнхийлөгчтэйгөө холбоо барьж, ерөнхийлөгч нь тэр даруй хэсэг эрэгтэйчүүдийг цуглуулан суулгацуудыг тарихад тусалжээ.

Мексикийн Пүэбла хотод гишүүд бие даах чадвартай болохоор зорьж буй хүмүүст дэмжлэг үзүүлэхээр Ла Маргаритагийн Донтолтоос ангижрах төв (La Margarita Addiction Rehabilitation Center)-д сургалт зохион байгуулсан аж. Эдгээр хүчин чармайлт нь хүмүүст эдгэрэх хүч чадал өгч, хоёр дахь боломжийг хүртэх эрхтэйг нь харуулсан юм.

Хүүхэд, эмэгтэйчүүдэд үйлчлэх

Тусламж хэрэгтэй хувь хүн, гэр бүлүүдэд материаллаг болон сүнслэг тусламж үзүүлэх нь Халамжийн нийгэмлэгийн (Сүмийн эмэгтэйчүүдийн байгууллага) үндсэн зорилго юм. Дэлхий даяарх Халамжийн нийгэмлэгийн эгч нар өдөр бүр энэхүү үүргээ биелүүлдэг.

Юта дахь Бригам Янгийн Их Сургуулийн 2024 оны Эмэгтэйчүүдийн чуулганы үеэр эмэгтэйчүүд Хангэр Файт (Hunger Fight) байгууллагад зориулж хоол савлахаас



авхуулаад тусламж хэрэгтэй хүүхдүүдэд зориулан чихмэл баавгай, хөнжил оёх зэрэг олон янзын үйлчлэлийн төсөлд оролцжээ.

Колумб дахь Сүмийн гишүүд, түүний дотор Халамжийн нийгэмлэг болон залуу эмэгтэйчүүдийн сайн дурынхан эмнэлэгт хэвтэж байгаа хүүхдүүдэд зориулж тоглоом цуглуулсан юм. Хүүхдийн хэсгийн хүүхдүүд хандивын эд зүйлстэй хамт өгөхөөр зураг зурж, захиа бичиж уг ажилд хувь нэмрээ оруулсан байна.

Өсвөр үеийнхэн ба залуучуудын үйлчлэл

Дэлхий даяарх өсвөрийнхөн 4-р сарын 26—28-ны хооронд Дэлхий дахины өсвөрийн үйлчлэлийн өдөрт оролцов. Аркансад 100 орчим өсвөр үеийнхэн цугларч, орон нутгийнхаа нуурын эрэг орчмын хогийг түүжээ. Канадад тусламж хэрэгтэй хүмүүст зориулан 90,000 хоол савлах ажилд оролцохоор Сүмийн болон орон нутгийн 200 гаруй сайн дурынхан JustServe дээр бүртгүүлсэн байна.

Сүмийн өсвөр үеийнхэн болон залуучууд жилийн турш үйлчлэлд оролцож, үйлчлэлийн төслүүдийг манлайлдаг. Өмнөд Виржиниагийн Их Сургуулийн залуучууд оюутнуудад үйлчлэлийн төслүүдэд оролцож, бусадтай холбогдоход нь зориулж “үйлчлэлийн булан”-г оюутны хотхондоо байгуулжээ. Юта дахь нэгэн чуулган дээр хэдэн зуун залуус тусламж хэрэгтэй хүүхдүүдэд зориулж ноосон хөнжил оёх, сэтгэл зүйгээ эрүүл байлгах тайтгаруулах иж бүрдэл бэлтгэх, хоол савлах зэрэг үйлчлэлийн олон төрлийн үйл ажиллагаанд оролцжээ.

Онцгой байдлын үед үйлчлэх

Чилид гарсан гал түймэрт хэдэн зуун суурин, орон гэр сүйдэж, олон оршин суугч толгой хоргодох газаргүй, амь зуух хэрэгцээт зүйлсгүй болсон байна. Үүний хариуд хэд хэдэн гадасны гишүүд савтай ус, бараа материал тарааж, гамшгийн дараах цэвэрлэгээний ажлыг зохион байгуулжээ.

Филиппинд гишүүд Канлаон галт уул дэлбэрсний дараа гэр орноо нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон хүмүүст зориулан хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл, ундны ус, ор дэрний хэрэгсэл бэлтгэх ажилд сайн дураараа оролцсон аж.

“Аврагч хэчнээн гайхамшигтай жишээг бидэнд үзүүлээ вэ. Энэ үлгэр жишээгээр дамжуулан бидний хүн нэг бүр эргэн тойрондоо байгаа нэг л хүнд тохинуулснаар Есүс Христийн хайрыг дэлхий даяар түгээж чадна.”

—РАССЭЛЛ М.НЭЛСОН, ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ³



Дээрээс доош: Тонга дахь Халамжийн нийгэмлэгийн эгч нар тойргийнхоо тусламж хэрэгтэй хүмүүст хоол бэлтгэж байгаа нь. Сүмийн гишүүд Гана улсад хүүхдийн хоол тэжээлийн үзлэгт сайн дураараа тусалж байна.



Бусдад үйлчилж буй номлогчид

Үйлчлэлийн номлогчид

Мянга мянган үйлчлэлийн номлогч Сүмийн халамжийн болон бие даах чадвар хөгжүүлэх үйл ажиллагаанд, түүний дотор хүнс үйлдвэрлэх, хангах, ажил хайж байгаа хүмүүст дэмжлэг үзүүлэх зэрэгт өөрсдийгөө зориулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тусалдаг номлогч ахлагч Ромэрил орон нутгийн оффист утасны дуудлагад хариулж, хувь хүмүүсийг ажил эрхлэлтийн эх сурвалжуудтай холбодог. “Та үйлчилж байхдаа өөрт тань хийж чадах олон зүйл байдгийг ойлгоно. Мөн Бурхан энэ чадварыг тань өсгөн нэмэгдүүлэх болно” гэж тэр ярилаа.

Яаралтай тусламж

Үйлчлэлийн болон сайн мэдээг номлодог номлогчдын аль аль нь гамшигт нэрвэгдэгчдэд туслах ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Швейцарт хүчтэй шуурга болсны дараа 33 залуу номлогч Валай руу очиж, гурван өдрийн турш цэвэрлэгээний ажилд тусалжээ. Энэхүү ажилд оролцсон нэгэн номлогч: “Бидний хийж буй ажил энд байгаа хүмүүсийн амьдралыг хэрхэн сайжруулж байгааг харах үнэхээр сэтгэл догдлом байна . . . Бид хүчээ нэгтгэснээр үнэхээр утга учиртай зүйлд хүрч чадсан” гэлээ.

1-р сард Японы Хокурику бүсэд 7.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болж, хэдэн арван мянган гэр орон эвдэрчээ. Үүнд арга хэмжээ авахаар орон нутгийн Сүмийн гишүүд бүрэн цагийн номлогчид нэгдэн цэвэрлэгээ хийх, бараа материал хүргэж өгөх, нүүлгэн шилжүүлэх төвүүд болон хоолны газруудад туслах зэрэг ажлыг хийсэн байна. Тухайн бүс дэх үйлчлэлийн номлогчид бас олон нийтийн хэрэгцээг шийдвэрлэхээр орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллажээ.

Олон нийтийн үйлчлэл

Номлогчид яаралтай тусламж үзүүлэхээс гадна дэлхий даяарх янз бүрийн олон нийтийн ажилд оролцож, үйлчлэл үзүүлдэг. Сүм Ганагийн Аксид Крисан гэх дүрвэгчдийн хуаран дахь гэр бүлүүдэд гудас, хоол хүнс, ус, шумуулын тор зэргийг хандивлажээ. Тухайн бүс нутагт үйлчилж байсан номлогчид хандивын эд зүйлсийг гэрт нь аваачиж, дүрвэсэн гэр бүлүүдэд тайтгарал, тайвшрал өгч тусалсан юм.

Албанийн номлогчид Христийн мэндэлсний баярын өдөр орон нутгийн асрамжийн газарт зориулж гар хийцийн хөнжил, баярын мэндчилгээний ил захидал хийжээ. Тэксас мужид номлогчид болон Сүмийн гишүүд тусламж хэрэгтэй хүмүүст зориулан хоол хүнс цуглуулах, тараах

ажилд олон нийтийг нэгтгэдэг Шашин хоорондын хоолны сагс хандивын хүнс (The Food Basket Interfaith Food Bank) байгууллагын шалыг засварлах JustServe төсөлд оролцсон байна. Номлогчид эдгээр жижиг үйлчлэлээр дамжуулан дэлхий даяарх хүмүүст Бурханы хайрыг мэдэрч материаллаг тусламж хүлээн авахад нь тусалдаг.

“Би дэлхий даяарх номлолуудаар айлчилж байхдаа маш олон ахмад номлогчийн гайхалтай үйлчлэлийг харж байсан. Тэд ‘Их Эзэний хүслийн’ дагуу үйлдэж, ‘Их Эзэний ажлыг’ хийж байхдаа аз жаргалтай байгаа нь илт байдаг.”

— РОНАЛД А.РАСБАНД, АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГА⁴



Японд номлогчид орон нутгийн ферм дээр үйлчилж байгаа нь.





Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний номлогч Хөдөлмөр эрхлэлтийн төвд нэгэн эмэгтэйд ажил хайхад нь тусалж байгаа нь.



Нэгэн номлогч эгч бишопын агуулахын тавиурыг дүүргэж байгаа нь.

Сүмийн олон гишүүн нийгэмд чиглэсэн үйлчлэлд оролцдог бол зарим нь номлогчоор үйлчлэн хүмүүнлэгийн ажилд нэмэлт цаг зав, авьяас чадвараа зориулдаг.

Олон ахмад настай, хос болон залуу хүмүүс хагас цагийн болон бүрэн цагийн үйлчлэлийн номлогчоор үйлчилж, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах олон нийтийн төслүүдийг зохион байгуулж, оролцдог билээ. Түүнээс гадна гэрлэсэн хосууд бүс нутагтаа хүмүүнлэгийн төслүүдийг удирдан зохион байгуулахаар бүрэн цагийн халамжийн болон бие даах чадвар хөгжүүлэх номлогчоор үйлчилдэг.

Бүрэн цагийн залуу номлогчид ч мөн олон нийтийн үйлчлэлд тогтмол оролцож, шаардлагатай үед байгалийн гамшгийн дараах цэвэрлэгээнд тусалдаг ажээ.



JustServe

JustServe бол үйлчлэлийн сүнснийг дэмжиж, орон нутгийн хэрэгцээг хангаж, олон нийтийн хамтын ажиллагааг уриалдаг хөдөлгөөн юм. Энэхүү үнэ төлбөргүй эх сурвалж нь хувь хүн, гэр бүл, бүлгүүдэд ач холбогдол бүхий үйлчлэлд оролцох боломж олгож, олон нийтийн байгууллагуудад төслөө нийтэлж, сайн дурынхныг олох платформоор хангадаг. JustServe нь 2012 онд байгуулагдсан цагаасаа хойш 165,000 гаруй олон нийтийн үйлчлэлийн төслийг зуучилжээ.

Бүхий л насны, янз бүрийн амьдралын туршлагатай сайн дурынхныг JustServe-д нэгдэхийг уриалдаг. Үйлчлэлд оролцогчид нь сайн үйлсээ хуваалцсанаар итгэл найдвар төрүүлж, оршин суугаа газар болон түүнээс ч өргөн хүрээнд өөрсдийн хувь нэмрийг оруулдаг.

Дэлхий даяарх өсвөрийнхний үйлчлэлийн өдөр

Дэлхий даяарх өсвөрийнхний үйлчлэлийн өдрөөр Өмнөд Калифорниагийн 240 гаруй өсвөр үеийнхэн JustServe ахлах сургуулийн клубуудын зохион байгуулсан үйлчлэлийн үйл ажиллагаанд оролцжээ. Тэдгээр сайн дурынхан орон нутгийн 80 гаруй сургуулийг төлөөлсөн ба зарим оролцогч үйлчлэлд хамрагдахаар олон цагийн аян замыг туулж ирсэн байна. Уг үйл ажиллагааны үеэр тэд 10 гаруй сайн үйлсийн байгууллагад тусалсан бөгөөд тэдгээрт нөхөрлөлийн бугуйвч хийх, оймс, хөнжил нэхэх, ахмад дайчдад захидал бичих, зурагт хуудас, эвлүүлдэг тоглоом зохион бүтээх, эмнэлэгт байгаа хүүхдүүдэд зориулж “нарны цацрагийн хайрцаг” хийх зэрэг ажил багтсан аж.

Тусламж хэрэгтэй хүүхдүүдэд үйлчлэх

5-р сард Лас Вэгасын өсвөр үеийнхэн Лас Вэгасын Рэскю Мишн буяны байгууллагад зориулж 91 шинэ ор угсарч өгч, хуучин орнуудыг нь Ийст Валли гэр бүлд туслах байгууллага дахь хүүхдүүдэд зориулан дахин ашиглахаар хамтран ажиллав. Төслийн зохицуулагчид эхэндээ 100 орчим хүн оролцоно гэж бодож байсан ч JustServe-ээр бүртгүүлсэн сайн дурынхны тоо өссөөр байсанд гайхжээ. Сүмийн хандиваар хэрэгжсэн уг төсөл нь тусламж хэрэгтэй хүмүүст нэн шаардлагатай зүйлсийг өгч, өсвөр үеийнхэнд нийгэмдээ идэвх оролцоотой байх үнэт боломжийг олгосон юм.

Шашин хоорондын үйлчлэл

Бага Мартин Лүтэр Кингийн өдрөөр янз бүрийн шашны тоо томшгүй олон сайн дурынхан олон нийтэд үйлчлэхээр цугларчээ. Тухайлбал: Индиана мужид Христ, Иудей, Лалын шашинтнуудыг төлөөлсөн JustServe ахлах сургуулийн клубын өсвөр үеийнхэн эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан Вийлэр номлолын төвд үйлчлэл зохион байгуулав. Тэд үдийн хоолоор үйлчилж, цэвэрлэгээ хийж, шинэ найз нөхөдтэй болсон юм.

4-р сард JustServe нь Аргентины Үндэсний номын үзэсгэлэн дээр асар ажиллуулж, 23,000 сайн дурынхныг шинээр бүртгэн авч, орон нутгийн төслүүдийг хэрхэн олохыг заасан байна. Уг асарт Сүмийн гишүүд болон өөр шашны сайн дурынхан ажилласан ба тусламж хэрэгтэй хүүхдүүдэд зориулан мянга мянган хичээлийн хэрэгслийн иж бүрдлийг урмын үгстэй зурвасуудын хамтаар бэлтгэсэн байлаа.

“Бусадтай мөр зэрэгцэн үйлчлэх нь гарал үүсэл, итгэл үнэмшлийн ялгаанаас болж өөр байдлаар харилцаж чадахгүй байж болох ч бие биеэ халамжлах нийтлэг үнэ цэнээр дамжуулан хамтдаа цуглах хэсэг бүлэг хүний хооронд гүүр тавихад тусалдаг гэдэгт бид итгэдэг.”

—ЖЭРАЛД КОССЭЙ, ТЭРГҮҮЛЭХ БИШОП*

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа ашгийн бус байгууллагуудын хэрэгцээг мэдэж ав.
- Орон нутагтаа зориулж JustServe дээр үйлчлэх боломжийг нийтэл.
- JustServe.org-оор дамжуулан бусдад үйлчил!





Дээрээс доош цагийн зүүний дагуу: Калифорния мужийн өсвөр үеийнхэн Дэлхий даяарх өсвөрийнхний үйлчлэлийн өдрөөр эмнэлэгт байгаа хүүхдүүдэд зориулан тоглоом, саатуулах зүйлсээр дүүрэн сав хийж байгаа нь. Аргентины Үндэсний номын үзэсгэлэн дээр JustServe-т бүртгүүлж байгаа сайн дурынхан. Сүмийн гишүүд Лас Вегас дахь Рэскю Мишн буяны байгууллагад зориулж шинэ орнууд угсарч байгаа нь. Хэсэг сайн дурынхан Юта муж дахь нэгэн голын эргийн хогийг цэвэрлэж байна.





Дэлхий даяар хэрэгжүүлж буй төсөл, санаачилга

“Ямар ч удирдагч Есүс Христээс илүү их эр зориг гаргаагүй, ямар
ч хүмүүнлэг үзэлтэн Түүнээс илүү нинжин сэтгэл харуулаагүй,
ямар ч эмч Түүнээс илүү их өвчнийг анагаагаагүй, ямар ч
уран бүтээлч Түүнээс илүү бүтээлч байгаагүй юм.”

—В.КРИСТОФЭР ВАДДЭЛЛ
ТЭРГҮҮЛЭХ БИШОПЫН ЗӨВЛӨЛИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ*



Илүү ихийг мэдэхийг хүсвэл кодыг уншуул.

2024 оны үйлчлэлийн хураангуй тайлан



3,836

2024 онд хэрэгжүүлсэн
хүмүүнлэгийн төслийн тоо



1.45B

Зардлын хэмжээ



6.6M

Сайн дурын ажилд
зарцуулсан цаг



192

Үйлчилсэн улс орон,
газар нутгийн тоо

Зардалд:

- ◆ Ерөнхийд нь үзүүлсэн тусламж
 - » Дэлхий даяарх хүмүүнлэгийн төслүүд
 - » Хоол хүнс, бусад бараа бүтээгдэхүүний хандив
- ◆ Эн тэргүүнд Сүмийн гишүүдэд олгосон тусламж
 - » Мацгийн өргөлийн тусламж
 - » Бишопын бараа бүтээгдэхүүний захиалга
 - » Халамж, бие даах чадвар хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулсан үйлчлэлүүд

Үйлчлэлд зарцуулсан цаг:

- ◆ Сүмийн халамж, бие даах чадвар хөгжүүлэх үйлчилгээний барилга байгууламж дахь сайн дурын ажил (бишопын агуулах, лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэр, фермийн аж ахуй, жимсний цэцэрлэг, хөдөлмөр эрхлэлтийн төв гэх мэт.)
- ◆ Олон улс орны тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах ажлууд
- ◆ Сүмээс ивээн тэтгэсэн гамшгийн дараах цэвэрлэгээ зэрэг нийгэмд чиглэсэн үйлчлэлийн төслүүд



Японд эхнэр, нөхөр хоёр орон нутгийнхаа цэцэрлэгийг арчилж байгаа нь.

“Мэдээж, [эдгээр] тоо баримт бидний юу өгдөг, хэрхэн тусалдаг талаарх гүйцэд бус тайлан юм. Эдгээрт дуудлагат ажлынхаа хүрээнд нэг нэгэндээ тохинуулсан, гишүүдийн бие биедээ сайн дураар үйлчилсэн хувь хүний үйлчлэлүүд ороогүй. Мөн энэхүү [хураангуй тайланд] гишүүдийн маань манай Сүмтэй албан ёсны харилцаагүй, энэрлийн тоо томшгүй олон байгууллагаар дамжуулан хувиараа үзүүлсэн тусламжийн талаар дурдаагүй болно.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ДАЛЛИН Х.ӨҮКС,
ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ



2024 оныг зурвасхан харвал

ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ХАЛАМЖЛАХ

Гишүүд, номлогчдын үйлчлэлийн тоо

8,097,952

Дэлхий даяарх Халамжийн
нийгэмлэгийн гишүүдийн тоо

12,277

Халамж, бие даах чадвар хөгжүүлэх
үйлчлэлийн номлогчдын тоо

JUSTSERVE

Нийгэмд чиглэсэн үйлчлэлийн
хөтөлбөрийн тоо

134,143

JustServe вэбсайтад шинээр
бүртгүүлсэн хэрэглэгчдийн тоо

30,236

JustServe вэбсайтад шинээр
нэмсэн төслүүд

ДЭЛХИЙ ДАЯАР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

Дэлхий даяар хэрэгжүүлсэн
төсөл, санаачилга

267

Цэвэр ус, эрүүл ахуй, ариун
цэврийн төслийн тоо

710

Яаралтай тусламж төсөл

732

Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээнд чиглэсэн төсөл

71

Хөдөлгөөний бэрхшээлд
чиглэсэн төслийн тоо

591

Хүнсний аюулгүй байдлыг
хангахад чиглэсэн төслийн тоо

БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ

Хөтөлбөр, үйлчлэлийн тоо

579

Боловсролд чиглэсэн төслүүд

10,809

Үйлчилсэн Дээрэт Индастрийс (Deser-
et Industries)-ийн туслах ажилтны тоо

2,503

Донтолтоос ангижрах долоо
хоног тутмын уулзалтын тоо

128,028

Бие даах чадвар хөгжүүлэх
бүлгийн оролцогчдын тоо





Номлогчид Бразилын Рио Грандэ до Сулд болсон ширүүн үерийн дараа яаралтай тусламжийн бараа материалыг онгоцноос буулгахад тусалж байгаа нь. Дивулгасао Azul (Divulgação Azul) компанийн гэрэл зураг.

Яаралтай тусламж

Байгалийн гамшиг, иргэний мөргөлдөөн зэрэг дэлхий нийтийг хамарсан онцгой байдал нь орон байр, хоол хүнс, ус, гамшгийн дараах цэвэрлэгээ, сэтгэл санааны дэмжлэг зэрэг олон саад бэрхшээлийг бий болгодог. Сүм хямралын үед тусламж хэрэгтэй хэн бүхэнд материаллаг болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, итгэл найдвар өгч, сэтгэлийн хаттай болгодог.

Сэтгэл зүйн анхны тусламж

Сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэхдээ хямралд орсон хувь хүмүүс болон олон нийтэд сэтгэлийн шаналлыг хэрхэн даван туулах аргад суралцахад тусалдаг. Сүм Гэр бүлд туслах байгууллагаараа дамжуулан хүнд байдалд орсон олон гишүүнд сэтгэл зүйн тусламж үзүүлсэн. Номхон далайн арлуудад Гэр бүлд туслах байгууллагын ажилтнууд улс төрийн үймээн самуунтай тулгарч буй хүмүүст зориулж сэтгэцийн эрүүл мэндийн нөөц боломжуудыг зохион байгуулсан аж. Эдгээр хүчин чармайлт нь Сүмийн олон гишүүнд сэтгэл санааны хямралаа даван туулж, бусдад дэмжлэг үзүүлэхэд тусалсан байна.

Түүнчлэн Сүм 2024 онд Бразилын Порто Алэгрэ хотод болсон үер; Чили дэх аймшигт гал түймэр; Калифорниагийн цэцэрлэгт хүрээлэнгийн түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн гишүүдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн. Энэхүү сэтгэл зүйн тусламж нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн сэтгэл санааны хямралыг анхан шатанд нь багасгаж, даван туулах чадварыг нь хөгжүүлэн хүчирхэгжүүлсэн юм.

Мөн Гэр бүлд туслах байгууллагын ажилтнууд хямрал болохоос өмнө бүсүүдийг бэлтгэдэг. Орон нутгийн Сүмийн удирдагчид тойрог, гадаснууддаа зориулж сэтгэл

санааны бэлэн байдлын сургалтыг зохион байгуулахаар Гэр бүлд туслах байгууллагын үйлчлэлийн зөвлөхүүдтэй холбоо тогтоож болдог. Жишээлбэл: Гэр бүлд туслах байгууллагын ажилтан Тэрэза, Соня хоёр Кабо-Вердед дэх өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх, сэтгэлийн тэнхээтэй байх, сэтгэл санааны хувьд бэлтгэлтэй байх зарчмуудыг зааж, тэднийг онцгой байдалд бэлтгэсэн юм.

Түүнээс гадна Сүм хүнд байдалд орсон хэн бүхэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэхээр янз бүрийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Хондурас улсад Сүм дүрвэсэн хүмүүст сэтгэл санааны анхан шатны тусламж үзүүлэх Хөүп (HOPE) төслийг дэмжсэн байна. Энэхүү хамтын ажиллагаа нь тусламж хэрэгтэй олон хүнд тус болж, хүнд хэцүү үед нь энэрэнгүй сэтгэлийн дэмжлэг үзүүлж байлаа.

Материаллаг тусламж

Онцгой байдлын үед Сүм болон Сүмийн гишүүд шашин шүтлэг харгалзахгүйгээр тусламж хэрэгтэй хүмүүст материаллаг тусламж үзүүлдэг. Сүм Ливанд хүнсний багц, ариун цэврийн иж бүрдэл, нарны зайн гар чийдэн зэрэг 10,000 гаруй хэрэгцээтэй зүйлийг хандивлан, дүрвэсэн гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлжээ. Румынд шилжин суурьшсан украинчууд хэлний бэрхшээл, хүүхэд асрах үйлчилгээний дутмаг байдал зэргээс болж ажил олох гэж зүдэрч байв. Сүм Асосиатиа Ла Раскрус (Asociatia La Rascurse) байгууллагад хоол хүнс, ариун цэврийн иж бүрдэл, халуун хоол хандивлаж, улмаар тус байгууллага нь тусламж хэрэгтэй украинчуудад тэдгээрийг тараахын зэрэгцээ гэрээсээ гарах боломжгүй өндөр настнуудад хоол хүргэж өгөх тогтолцоог хэрэгжүүлжээ.





Зүүн талд: Сирид нэгэн эмэгтэй түр хоргодох байрныхаа гадаа хоол хийж байгаа нь. Шэлтэрбокс (ShelterBox)-ийн гэрэл зураг. **Баруун талд:** Хэлэн хар салхины сүйрлийн дараа хоёр эмэгтэй тэврэлдэж байгаа нь.

Чилид Сүм болон тусламжийн хэд хэдэн байгууллага ойн аймшигт гал түймэрт нэрвэгдсэн хүмүүст туслахаар хамтран ажилласан юм. Гамшигт нэрвэгдсэн бүсүүдэд түр хугацаагаар боловсрол олгох, хоол хүнс түгээх цэгүүдийг байгуулсан байна. Виниа дэл Мар, Күилпүэ, Валпарайсо дахь Сүмийн гишүүд хэрэгцээт зүйлс тараах болон цэвэрлэгээний ажилд туслахаар сайн дураараа оролцжээ. Сүм бас гамшигт нэрвэгдсэн гэр бүлүүдэд туслахын тулд их хэмжээний хандив өргөсөн байна.

Би юу хийж чадах вэ?

- Онцгой байдлын тусламж шаардлагатай нөхцөл үүсэхэд тусламж үзүүлдэг байгууллагаар дамжуулан мэргэшсэн сайн дурын ажилтан болох
- Болзошгүй хямралын нөхцөл байдалд бэлтгэхэд туслах онцгой байдлын хувийн төлөвлөгөө гаргах
- Хүнд хэцүү цаг үед танд туслах Сүмийн вэбсайт дээрх сэтгэл санааны тусламжийн картуудыг татаж авах

“Бид дэлхийг хүн бүрийн хувьд илүү дээр газар болгохын тулд хол ойрын хөршүүддээ тохинуулахыг эрэлхийлдэг.”

—ЖЭРАЛД КОССЭЙ, ТЭРГҮҮЛЭХ БИШОП®

Филиппинд хамтдаа үйлчилсэн нь

2024 онд Филиппинд далайн хар салхи, галт уулын дэлбэрэлт, гал түймэр, Эл Ниниогийн ган гачгийн үр дагавар зэрэг хэд хэдэн гамшиг тохиожээ. Сүм засгийн газрын онцгой байдлын хариу арга хэмжээ үзүүлэх үйлчилгээтэй хамтран тусламжийн бараа бүтээгдэхүүнээр хангаж, орон нутгийн гишүүд тэдгээр барааг боож баглах, тараах ажилд өөрсдийн цаг зав, хүчин чармайлт, хайр энэрлээ зориулж байлаа.

Сэбү хотын захирагчийн үүрэг гүйцэтгэгч Рэймонд Алвин Гарсиа Сүмийн тусламжид талархлаа илэрхийлэн, “Хотын захиргаа харьяат иргэддээ тусалж, үйлчлэхийн тулд байгаа ч бид хүн бүрд хүрч тусалж чадахгүй гэдгээ мэднэ. Тиймээс өнөөдөр бид түншүүд, аж ахуйн нэгжүүд болон Сүм бидний ажил үүрэгт хэрхэн тусалж байгааг харж байна. Та бүхэнтэй адил байгууллагуудын ачаар бидний ажил хялбар болж байна. Тиймээс манай иргэдэд, ялангуяа уулын барангайчуудад хандив өргөсөнд тань бид маш их талархаж байна” гэжээ.



Цэвэр ус ба бохирын систем

Цэвэр ус, бохирын систем, эрүүл ахуйн (WASH) хүртээмж олон нийтийг эрүүл байлгах үндэс суурь юм. Бохирын системийг сайжруулж, өвчний тархалтыг бууруулахын тулд олон нийтэд шаардлагатай багаж хэрэгсэл, мэдлэг боловсрол хэрэгтэй. Сүмийн цэвэр ус, ариутгал цэвэрлэгээнд зориулж буй хүчин чармайлт нь шашин шүтлэгээс үл хамааран хүн бүрийн ашиг тусын тулд байдаг.

WASH санаачилгууд

Сүм 2024 онд НҮБ-ийн хүүхдийн сангийн Өмнөд Америк, Африк, Номхон далайн арав гаруй оронд WASH хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг дэмжсэн билээ. Сүм Угандад тусламж хэрэгтэй иргэдийг цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах ВатэрЭйд (WaterAid) ажлыг дэмжсэн юм. Тэд цэвэр усны цооног буюу найман шугамтай усны системийг амжилттай суурилуулсан ба энэ нь 2,500 гаруй хүнд ашиг тусаа өгчээ. Тэд шинэ усны системээс гадна шинээр байгуулсан худаг бүр дээр эрүүл ахуй, ариун цэврийн сургалтыг нэвтрүүлсэн байна. Тэд урт хугацааны арчилгааг хангахын тулд орон нутгийн иргэдэд усны хангамжийг ажиллуулж, арчилж тордох талаар сургалт өгч, засварын арга техникийн талаар мэдлэг олгожээ.



Эквадор нэгэн охин гараа цэвэр усаар угааж байгаа нь. Эквадор дахь НҮБ-ийн хүүхдийн сангийн гэрэл зураг.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа ус, бохир зайлуулах, эрүүл ахуйн ажлын талаар илүү ихийг мэдэж ав.
- Хүүхдэд гараа хэрхэн угаахыг зааж өг.
- Шаардлагатай үед илүү цэвэр устай байхын тулд ус нөөцөлж эхэл.

Цэвэр усны төлөөх олон нийтийн хамтын ажил

Косово дахь Карралэва тосгоны худаг хатаж, усгүй болсны улмаас тус тосгоны есөн том гэр бүл аюултай байж болзошгүй эх үүсвэрээс бидоноор усаа зөөхөөс өөр аргагүй болсон байна. Сүм орон нутгийн оршин суугчидтай хамтран тосгоны бүх хүнийг цэвэр усаар хангахын тулд усны нөөцийн санг барьжээ.

Балканы олон газарт усны систем нь ихэнхдээ хуучирсан эсвэл бүр огт байдаггүй аж. Өвлийн улиралд халаалтын эрчим хүчний хэрэгцээ цахилгааны чадлаас байнга хэтэрдэг байна. Сүм энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Хани и Элэзит хотын оршин суугчдад нөөц цахилгаан үүсгүүр хандивлажээ. Энэхүү хүчин чармайлт нь оршин суугчдыг өвлийн турш усаар тасралтгүй хангах боломжийг олгосон юм.

Бохирын системийн аюулгүй ажиллагааг нэвтрүүлэх

“Каскаст бидэнд юу дутагдаж байгаа билээ” гэж би асуусан” хэмээн Алэксандра дурсав. Түүний санаанд хамгийн түрүүнд орж ирсэн хэрэгцээтэй зүйл бол ариун цэврийн өрөө байсан юм.

Алэксандра Перугийн Каскаст амьдардаг бөгөөд тус газарт амьдардаг гэр бүлүүдийн 20 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан бохирын системийн хувьд учир дутагдалтай байгааг тэр мэддэг байжээ. Эрүүл ахуйн шаардлага хангасан бохирын систем байхгүйгээс болж олон нийт холер гэх мэт усаар халдварладаг өвчнөөр өвчлөх эрсдэл ихтэй байв. Энэ асуудлыг шийдэхийн тулд Алэксандра Перу дахь орон нутгийн Ватэр фор Пийпл (Water for People) багийн зохион байгуулсан бохир зайлуулах бизнесийн сургалтад хамрагдсан байна.

Алэксандра хувийн бизнесээ эхлүүлж, угаалтуур, цорго, жорлон, паалантай хавтан зэрэг угаалгын өрөө барихад шаардлагатай материалуудыг жижиг дэлгүүртээ боломжийнхоо хэрээр нөөцлөв. Одоо Каскас дахь гэр бүлүүд Алэксандрагийн дэлгүүрийн тусламжтайгаар, гэртээ угаалгын өрөө барихад шаардлагатай материалуудыг худалдаж авах боломжтой болжээ.



Боловсрол

Бие даах чадвараа дээшлүүлэхэд боловсролын хүртээмж чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүм хувь хүмүүст чадавхаа бүрэн ашиглахад нь туслах эх сурвалж өгч, дэмжлэг үзүүлснээр дэлхий даяарх гишүүд, найз нөхдийнхөө боловсролын хэрэгцээг хангахыг зорьдог.

Сүмийн гишүүдэд зориулсан эх сурвалжууд

Тасралтгүй Боловсролын Сан (ТБС) хөтөлбөр нь шаардлага хангасан Сүмийн гишүүдэд илүү сайн ажил, илүү бие даасан байдалд хүргэх боловсрол олж авахад нь тусалж, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг билээ. Сүмийн Тэргүүн зөвлөл саяхан уг хөтөлбөрт өөрчлөлт оруулж, илүү олон хүнд ТБС-аас тусламж авах боломж олгосон юм. Эдгээр өөрчлөлтөд зээлийн хөнгөлөлт, зээлийн урт хугацаа, тэтгэлэг, боловсролын өргөжүүлсэн сонголт зэрэг орсон. Нөхцөл байдлаас шалтгаалан, тэтгэлэг авсан хүмүүс байр, тоног төхөөрөмж, унаа тээвэр зэрэг боловсролтой холбоотой нэмэлт зардалдаа ТБС-ийн мөнгийг ашиглаж болно.

Сүм гишүүддээ боловсролын бусад эх сурвалжийг олгодог. Үүнд:

- ◆ **BYU-Pathway Worldwide** нь гишүүдэд дээд боловсролыг онлайнгаар, боломжит төлбөрөөр олж авахад тусалдаг.
- ◆ **Бэнсоны нэрэмжит тэтгэлэг** нь хүнс тэжээл, хөдөө аж ахуйн салбарт дундаас дээш боловсрол эзэмшихийг хүсэж буй гишүүдийг дэмждэг.
- ◆ **EnglishConnect** нь Сүмийн гишүүн бус хүмүүс зэрэг сонирхсон бүх хүнд англи хэлний хичээлийг үнэ төлбөргүй заадаг.
- ◆ **Succeed in School** хөтөлбөр нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх ур чадварыг хөгжүүлэхэд нь өсвөр үеийнхэнд тусалдаг.

Ерөнхийд нь олгосон эх сурвалжууд

Сүм бас дэлхий даяарх боловсролын хэрэгцээг дэмжих үүднээс сэргээн засварлалт, багшийг хөгжүүлэх сургалт зэргийг санхүүжүүлж, ширээ, сандал, интернэт, сурах бичиг зэрэг төхөөрөмж хэрэгслээр хангадаг. Сүм боловсролд чиглэсэн олон зуун төсөл хэрэгжүүлсний нэг нь Либерийн Запайн улсын сургуульд томоохон засвар хийж, ариун цэврийн өрөөнүүдийг нь засаж, цахилгааны шугам суурилуулж, 300 шинэ сандал аваачсан явдал юм. Энэхүү засварын ажил сургуулийн сурагчдын тоог нэмэгдүүлэх болно.



Нэгэн япон охин тоолж сурч байгаа нь.

ТБС-аар дамжуулан мөрөөдөлдөө хүрэх

Принцэсс үйлчлэлийн номлолоосоо буцаж ирэнгүүт мэргэжлийн нягтлан бодогч болох мөрөөдөлдөө анхаарлаа хандуулсан аж. Дээд боловсролын өртөг үнэхээр өндөр байсан ч Филиппиний Катандуанэсын тус залуу эмэгтэй Тасралтгүй Боловсролын Сангийн ачаар зорилгоо биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг авч чадсан байна. Принцэсс одоо нягтлан бодох бүртгэлийн сургуульд төгсөх жилдээ сурч байна.

“[ТБС] надад мэргэшсэн нягтлан бодогч болох мөрөөдлөө биелүүлж, чадах хэмжээгээрээ боловсрол эзэмш гэсэн ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны зөвлөгөөг дагах гүүр болсон юм. Би Их Эзэн бидний зөв шударга хүслүүдийг үргэлж анхаардаг гэсэн гэрчлэлтэй болсон” гэж Принцэсс хэлэв.

Би юу хийж чадах вэ?

- Хэн нэгэнд гэрийн даалгавраа хийхэд нь тусал.
- Ангид сайн дураараа оролц.
- Гэр бүл, найз нөхдөдөө боловсрол олж авах эх сурвалжуудын талаар ярьж өг.





Зүүн талд: Үйл ажиллагааны ахлах ажилтан Дэээрэт Индастрийсын туслах ажилтнуудыг борлуулалтын хэсэг дээр сургаж байгаа нь.
Баруун талд: Нэгэн эрэгтэй Хөдөлмөр эрхлэлтийн төвд ажил хайх тусламж авч байгаа нь.

Хөдөлмөр эрхлэлт

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хувь хүмүүст бие даах чадварыг нь дэмжих эх сурвалжуудаар хангаж тусалдаг. Үүнд ажил хайх болон ажилд тэнцэхэд нь туслах үйлчилгээ, эх сурвалжууд багтдаг.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь ажилгүй, илүү сайн ажил хайж байгаа эсвэл эргээд ажил хийх гэж байгаа бүх хүнд зориулсан эх сурвалж юм. Хөдөлмөр эрхлэлтийн номлогчид олон төрлийн дэмжлэг үзүүлдэг:

- ◆ Товч намтар бичихэд туслах
- ◆ Ярилцлагад бэлтгэх
- ◆ Ажлын зар мэдээллээр хангах
- ◆ Холбоо харилцаа тогтоох

Хөдөлмөр эрхлэлтийн төв нь Сүмийн гишүүд болон бусад хүнд зориулж эх сурвалжуудыг ашиглах, биечлэн тусламж авах төвүүдийг ажиллуулдаг. Ажил хайж буй хүмүүс онлайн бүлэг, сургалт, онлайн көүч, онлайн ажлын зар зэрэг цахим үйлчилгээнүүдэд нэвтрэхийн тулд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний employment.ChurchofJesusChrist.org вэбсайт руу орж болно.

2024 оны эхээр Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ олон улсын хэмжээнд өргөжин тэлж, дэлхий даяарх хүмүүст хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг туслалцааг хүргэх, эх сурвалжуудыг ашиглах боломж олгосон.

Дэээрэт Индастрийс

Дэээрэт Индастрийс (ДИ) бол ажил хийхэд саад бэрхшээлтэй тулгарч байгаа Сүмийн гишүүд болон бусад хүнд зориулсан ажлын сургалтын газар болгон ашигладаг хуучин барааны дэлгүүр юм. Хувь хүмүүс ДИ-ийн Ажилд бэлэн (Ready for Work) хэмээх ажилд бэлтгэх хөтөлбөрөөр дамжуулан ажлын сургалт, гэрчилгээ авдаг. Ажилд бэлэн хөтөлбөр нь ажлын ур чадвар заахаас гадна ажилдаа амжилт гаргахад зайлшгүй шаардлагатай зан төлөвийн ур чадваруудыг анхаарч үздэг.

Дэээрэт Индастрийсын туслах ажилтнууд үйл ажиллагааны ахлах ажилтан, хөгжлийн зөвлөхүүд зэрэг бүрэн цагийн ажилтнуудаар сургагддаг. 2024 онд ДИ-ийн 46 байршлын үйл ажиллагааны ахлах ажилтнууд өөрсдийн удирдлага доорх туслах ажилтнуудаа дэмжихэд бэлтгэгдэхээр сургалтад хамрагдсан байна. Эдгээр сургалтад ажил мэргэжил, манлайллын хөгжүүлэлт, стандартын хэрэгжилт, харилцагчийн үйлчилгээ, хүний нөөц зэрэг сэдвүүд багтсан.

Хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээ

Хөгжүүлэлтийн зөвлөхүүд нь ДИ-ийн ажилтнууд болон Сүмийн удирдагчаас санал болгосон бүх хүнд зорилго тавих, ажил мэргэжлээ төлөвлөхөд тусалдаг мэргэшсэн мэргэжилтнүүд юм. Тэд хувь хүний сайн сайхан байдал, хэрэгцээг үнэлж, зөвлөгөө өгч, мэргэжлийн үнэлгээ, боловсролын дэмжлэг үзүүлдэг.



Хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээ (ХЗҮ) нь ажил эрхлэхэд тулгардаг саад бэрхшээлийг даван туулахад нь хувь хүмүүст туслахын тулд Гэр бүлд туслах байгууллага, Дээрэт Индастрийс, Хөдөлмөр эрхлэлтийн төв зэрэг Сүмийн бусад эх сурвалжтай хамтран ажилладаг. ДИ-ийн туслах ажилтнууд Ажилд бэлэн хөтөлбөрийн хүрээнд ажлын байрны чухал зан авирыг сурахаар ХЗҮ-ийн зөвлөхүүдтэй хамтран ажилладаг. Түүнчлэн хөгжүүлэлтийн зөвлөхүүд Гэр бүлийн болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээтэй нягт хамтран ажиллаж, хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн болон ажил эрхлэлтийн дэмжлэг авахад тусалж, тэднийг эдгээр эх сурвалжтай холбож өгдөг.

Шилжилтийн үйлчилгээ

Сүм АНУ даяар Шилжилтийн үйлчлэлийн есөн албатай. Шилжилтийн үйлчилгээг нийгэмдээ эргэн дасан зохицоход тусламж хэрэгтэй байгаа хүн бүрд, түүний дотор засан хүмүүжүүлэх газраас гарч байгаа хүмүүс, хүний наймаанаас аврагдсан эмэгтэйчүүд, халагдсан цэргүүд, орон гэргүй болсон хүмүүст үзүүлдэг.

Шилжилтийн үйлчилгээ нь хувь хүмүүсийг ажил эрхлэлт, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нийгмийн болон Сүмийн эх сурвалжуудтай холбон бие даах чадвартай болоход нь туслахад анхаардаг.

Хүмүүнлэгийн төв

Сүмийн Хүмүүнлэгийн төв нь Дээрэт Индастрийсын дэлгүүрүүдээс илүү гарсан хандивыг хүмүүнлэгийн тусламжид зориулан дахин боловсруулдаг. ДИ-ийн адилаар тус төв нь хүмүүст ажил эрхлэх ур чадварыг олж авахад нь туслах сургалтын орчин болдог. Туслах ажилтнуудын дунд өөр өөр улс орноос ирсэн, өөр өөр шашин шүтлэгтэй, англиар чөлөөтэй ярьдаггүй хүмүүс олон байдаг. Туслах ажилтнууд ажлынхаа хүрээнд англи хэл сурах боломжтой.

“Би хэн нэгнийг хайрлах хамгийн сайн арга бол тэдэнд туслах явдал гэж боддог байсан. Гэхдээ энэ талаар бодох тусам хэн нэгэнд туслах хамгийн сайн арга бол тэднийг хайрлах явдал гэж бодсон.”

—Л.ТОДД БАЖ, ТЭРГҮҮЛЭХ БИШОПЫН
ЗӨВЛӨЛИЙН ХОЁРДУГААР ЗӨВЛӨХ⁹

Дий мөрөөдлийн ажлаа олсон нь

Дий 14 жил хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлснийхээ дараа эргээд ажил хийхийг хүсэж байсан ч юу хийхээ сайн мэдэхгүй байлаа. Бишоп нь түүнийг Хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээтэй холбож өгөхөөс өмнө тэрээр гурван өөр ажил туршиж үзжээ.

Дий хөгжүүлэлтийн зөвлөхтэй тогтмол уулзаж, ямар ажил өөрт нь хамгийн тохиромжтойг мэдэхийн тулд янз бүрийн үнэлгээ, зан чанарын сорил бөглөдөг байв. Хэсэг хугацаанд ажил хайсны дараа хөгжүүлэлтийн зөвлөх нь түүнд өөрийнх нь ажиллаж байсан Дээрэт Индастрийст удирдлагын бичиг хэргийн ажилтны ажилд орохыг зөвлөжээ. Дий уг ажил өөрийнх нь зан чанар, сонирхолд нийцэж байгааг тэр даруй ойлгож, ажилд орсон аж. Дий: “Би өөрийгөө хаана ч тохирохгүй гэж бодож байсан ч өөрийн байх ёстой газраа олсон! Би энд байгаадаа маш их баяртай байна. Би хөгжүүлэлтийн зөвлөхдөө маш их талархаж байна” гэжээ.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа Дээрэт Индастрийс эсвэл үүнтэй төстэй ажлын сургалт явуулдаг хуучин барааны дэлгүүрт эд зүйлсээ хандивла.
- Найз эсвэл гэр бүлийнхээ гишүүний товч намтрыг хянаж өг.
- Сүмийн хөдөлмөр эрхлэлтийн эх сурвалжуудын тухай илүү ихийг мэдэж авч, тэдгээрийг ашиглахад бусдыг урамшуулан дэмж.



Байгаль орчин хамгаалах

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм тусламж хэрэгтэй хүмүүсийг төдийгүй эх дэлхийгээ халамжлах ажлыг эрчимжүүлсээр байна. Хувь хүний болон нийгмийн сайн сайхан байдал нь эрүүл байгаль орчинтой нягт холбоотой байдаг учир хүрээлэн буй орчны тогтвортой байдал Сүмийн эрхэм зорилгын салшгүй хэсэг юм.

Сүм 2024 онд Тогтвортой хөгжлийн албаа өргөжүүлсэн бөгөөд энэ нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашигтай байдлыг дэмжих, ус хэмнэх, материалын хог хаягдлаас зайлсхийх, тээврийн хэрэгслээс ялгарах утааг багасгах, тогтвортой барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барьж байгуулах, тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуй эрхлэх зэрэг зургаан үндсэн чиглэлээр дэлхий дахины санаачилгуудыг зохицуулдаг.

Хүмүүнлэгийн ажил

Байгаль орчны тогтвортой байдал бол Сүмийн хэрэгжүүлдэг хүмүүнлэгийн олон төслийн нэг юм. Уур амьсгалд илүү сайн дасан зохицож, уян хатан байх нь хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдал, цэвэр усны хүртээмжийг сайжруулдаг.

Тухайлбал: Сүм Суданд нарны эрчим хүчээр ажилладаг усны насосуд суурилуулж, орон нутгийн усны хорооны гишүүдийг засвар үйлчилгээ болон менежментийн хүрээнд сургахаар АДРА (ADRA)-д хандив өргөжээ. Түүнчлэн Сүм Курдистанд нарны эрчим хүчээр ажилладаг 4 сургууль барих Католик Тусламжийн Үйлчлэл (Catholic Relief Services)-ийн ажлыг дэмжсэн байна.

Материалын ашиглалт

АНУ, Канад даяарх Сүмийн үйл ажиллагаанд ашигласан бүх хуучин электрон хэрэгслийг хогийн цэг дээр хаядаггүй. Үүний оронд Сүм жил бүр хэдэн зуун компьютерыг орон нутгийн болон олон улсын энэрлийн байгууллагуудад хандивладаг. Дахин ашиглах боломжгүй электрон хэрэгслийн хувьд металл болон бусад эд ангийг дахин боловсруулдаг.

Сүмийн тэргүүлэгч хэвлэлийн төв нь судар, хичээлийн гарын авлага зэргийн хэвлэлтээс илүү гарсан цаасны хаягдлыг нямбайлан боож, цаас ханган нийлүүлэгчдэд буцааж өгч, дахин боловсруулалтад оруулдаг.

Латин Америкт Сүмийн дэлгүүрүүд хуванцар уут, баглаа боодлын оронд байгальд задардаг, дахин ашиглах боломжтой уут ашиглаж байна. Түүнээс гадна, Перуд байрладаг сэтгүүл хэвлэх үйлдвэр нь одоо тогтвортой эх үүсвэр бүхий мод хэрэглэдэг болжээ. Бразилд өсвөр үеийнхний зарим чуулганд дахин боловсруулж болох футболк хэрэглэж байна.



Мексикийн Пэтэн-Плайя дэл Кармэн дахь Сүмийн цуглааны байр нарны эрчим хүч хураагч хавтан ашигладаг.

“Хэрэв бид дэлхийн элбэг дэлбэг хийгээд үзэсгэлэнт байдлыг хадгалан хамгаалахыг хүсдэг юм бол, энэ ажлын ихээхэн хэсэг нь гэр орны маань хананы дунд, гэр бүл дотор маань хийгдэх болно.”

—ПАТРИК КИЙРОН

АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГА¹⁰

Би юу хийж чадах вэ?

- Дахин ашиглах боломжтой эсвэл байгальд задардаг уут, усны сав ашигла.
- Цэнэг хураагуур, эм, будаг зэрэг хортой хог хаягдлыг зохих ёсоор хая.
- Бараа бүтээгдэхүүнийг солих биш, харин засаж янзалж сур.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба хөдөлгөөний бэрхшээл

Есүс Христ мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үеэр хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүсийг халамжилж байсан. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхий даяар энэхүү зорилгыг биелүүлж, тусламж хэрэгтэй хүн бүрд янз бүрийн хөтөлбөрөөр дамжуулан эрүүл мэндийн тусламж болон хөдөлгөөнт хэрэгслийн дэмжлэг үзүүлсээр байна.

Хараа зүйн тусламж

Сүмээс Папуа Шинэ Гвиней Улсын Порт Морэсбид нарны эрчим хүч болон мэдээ алдуулагч технологиор тоноглогдсон барилга байгууламжийн ажлыг санхүүжүүлэхэд тусалсан юм. Фред Холлоуз сан (The Fred Hollows Foundation), Папуа Шинэ Гвиней Улсын Үндэсний Эрүүл Мэндийн Газар, орон нутгийн их сургуулиуд зэрэг байгууллагууд хамтран тус байгууламжийн үйл ажиллагааг хариуцдаг ба тус байгууламж нь нүдний эрүүл мэндийн тогтолцоог сайжруулж, бүс нутгийн хараа зүйн зорилтуудад хүрэх зорилготой билээ. Сургалтын хөтөлбөр нь төгсөгчдөд чадварлаг нүдний эмч мэргэжилтэн болоход тусалж, Папуа Шинэ Гвинейн нүдний эрүүл мэндэд урт удаан хугацааны нөлөө үзүүлжээ.

Дархлаажуулалт

2024 онд Сүм Этиоп улсын дархлаажуулалтад хамрагдах байдлыг нэмэгдүүлэх зорилгоор НҮБ-ийн Хүүхдийн сангийн үйл ажиллагаанд хандив өргөж, вакциныг хүртээмжтэй, эрх тэгш болгожээ. Уг хамтын ажиллагаа нь тус улсын вакцинжуулалтын түвшнийг нэмэгдүүлж, илүү олон хүүхдийг урьдчилан сэргийлж болох өвчнөөс хамгаалж, Этиопийн иргэдэд эрүүл ирээдүйг бий болгосон байна.

COVID-19 цар тахлын үед сургуулиуд хаагдсаны улмаас Малайзын хагас сая гаруй эмэгтэй умайн хүзүүний хорт хавдрын вакцин хийлгэх боломжгүй байв. Сүм Малайзын Үндэсний Хорт Хавдрын Нийгэмлэгт хандив өргөн, тус улсын зүүн хэсэгт амьдардаг эмэгтэйчүүдэд амь нас аврах энэхүү вакциныг хийлгэхэд нь тусалсан аж.

Бүх хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх

Сүм тусламж хэрэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах олон төслийг дэмждэг. Эквадорын Кито хотод Сүм 19,200 гаруй хувь хүн, гэр бүлд халамж үйлчилгээ, эрүүл ахуйн иж бүрдэл олгож, тэдний амьдралын нөхцөлийг сайжруулсан байна. Венесуэлд Сүм

Хөүп (HOPE) төсөлтэй хамтран эхчүүд, асран хамгаалагчид, хүүхдүүдэд эрүүл мэнд, хоол тэжээл, сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлжээ.

Сүм дэлхий даяарх хүүхэд, эмэгтэйчүүдийн сайн сайхан байдлын төлөө хэрэгжүүлж буй Халамжийн нийгэмлэгийн санаачилгатай уялдуулан эх, нярайн асаргааг дэмжих төслүүдэд анхаарал хандуулдаг. Африкийн зарим хэсэгт нярайн эндэгдэл дэлхийд хамгийн өндөр түвшинд байдаг. Үүний хариуд Сүм эрүүл мэндийн ажилтнуудыг сургаж, нярайн эндэгдлийг бууруулахад туслах зорилгоор бусад байгууллагатай хамтран ажилладаг. Сүм Америкийн Нэгдсэн Улс даяарх хар арьстай ард иргэдийн дундах нярайн эндэгдлийг бууруулахын тулд Өнгөт арьстай хүмүүсийн хөгжлийн үндэсний холбоо (NAACP)-той хамтран ажилладаг.

Сьерра Леонд тэргэнцэр хандивласан нь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хандивын ачаар Сьерра Леоны Фрийтаун дахь олон зуун хүн тэргэнцэр, суга таяг, цагаан таяг хүлээн авчээ. Энэхүү дэмжлэг нь орон нутгийн техникч, хөдөлгөөн засалчдад зориулсан сургалтын хамтаар хөдөлгөөн, бие даасан байдлыг ихээхэн сайжруулсан.

Хүүхэд байхаасаа мөлхсөн нэгэн хүн шинээр олж авсан эрх чөлөө, бахархалдаа гүнээ талархаж байгаагаа илэрхийлжээ.

Би юу хийж чадах вэ?

- Вакцины талаар илүү ихийг мэдэж авч, хүн бүрийг мэдээлэлтэй болгохын тулд олж авсан мэдлэгээ найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хуваалц.
- Бүс нутагтаа харааны үзлэг болон эрүүл мэндийн үзэсгэлэнд сайн дураараа оролц.
- Бие нь тааруу байгаа хүнд хоол хийж өг.





Гана дахь хүүхдүүд оройн хоол хийхэд тусалж байна.

Өлссөнийг хооллох

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст туслахын тулд юуны түрүүнд тэдний наад захын хэрэгцээг шийдвэрлэж, дараа нь бие даах чадварыг нь хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөг дэмждэг. Сүм энэ ажлынхаа хүрээнд нэн тэргүүний хэрэгцээг шийдвэрлэх төслүүдэд хандив өргөж, урт хугацааны хүнсний аюулгүй байдалд анхаардаг бусад байгууллагатай хамтран ажиллаж, түүнчлэн хүүхдийн хоол тэжээлийн өөрсдийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Бараа бүтээгдэхүүний хандив

Сүм 6 улс оронд бишопын 122 агуулахыг ажиллуулдаг. Орон нутгийн Сүмийн удирдагчид хүнс болон бусад зайлшгүй шаардлагатай зүйлсээр дүүрэн эдгээр агуулахыг цуглааныхаа тусламж хэрэгтэй гишүүдэд үйлчлэхэд ашигладаг. Сүм агуулах байхгүй газарт хэрэгцээтэй бараагаар хангахын тулд орон нутгийн хүнсний сүлжээ дэлгүүрүүдтэй хамтран ажилладаг билээ.

Бишопын агуулахууд гишүүдийн хэрэгцээг хангахаас гадна Америкийн Нэгдсэн Улс, Канад даяарх буяны байгууллагуудад хоол хүнс, бараа материал тараадаг. 2024 онд бишопын агуулахуудаас 17.7 сая килограмм хүнсийг хүмүүнлэгийн байгууллагууд болон хандивын хүнс тараах цэгүүдээр дамжуулан хандивласан бөгөөд энэ нь тусламж хэрэгтэй хүмүүст зориулсан 32 сая орчим хоол гэсэн үг юм. Жишээлбэл: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Юта мужийн Солт Лэйк Сити дахь Католик шашны олон нийтийн үйлчлэлд хандив өргөж, орон гэргүй хүмүүс болон Католик шашны олон нийтийн үйлчлэлийн хүнсний хангамжаас тусламж хүссэн хүмүүсийг хоол хүнс, аюулгүй байдлаар хангажээ.

Испанид дүрвэн ирэгсдийн тоо ойрын үед ихээр нэмэгдэж байгаа учир Сүм тусламж хэрэгтэй хүмүүст бараа бүтээгдэхүүн хүргэх шинэ машин худалдаж авахад нь Эл Хогар Буэн Самаритано (El Hogar Buen Samaritano) байгууллагад дэмжлэг үзүүлсэн.

Гишүүдэд төвлөрсөн Хүүхдийн хоол тэжээлд чиглэсэн ажил (Child Nutrition Effort)

Дэлхий даяар 0-5 насны олон хүүхэд хоол тэжээлийн дутагдалд ордог. Сүмийн Хүүхдийн хоол тэжээлийн (Child Nutrition Effort) төсөл нь гишүүн хүүхдүүдэд өсөж торних, бие махбод, оюун санаа, сүнслэг байдлын чадавхдаа бүрэн хүрэхэд нь туслах зорилготой. Хүүхдүүдийг хоол тэжээлийн дутагдлын үзлэг шинжилгээнд хамруулдаг бөгөөд тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ хоол тэжээлийг сайжруулахад туслах эх сурвалж, боловсрол олгодог юм. Хөтөлбөрийг хаана ч зохион байгуулсан гэсэн иргэд, гишүүдийг оролцоход урьдаг.

Сүм гишүүдэд төвлөрсөн хөтөлбөрөөс гадна хүүхдийн хоол тэжээлийг эн тэргүүнд тавьдаг дэлхий даяарх бусад байгууллагыг дэмждэг. 2024 оны 6-р сард Сүм эх, хүүхдийн эрүүл мэндэд хувь нэмэр оруулдаг найман байгууллагад хандив өргөхөө зарласан. Түүнээс гадна хоол тэжээлийн дутагдлыг эмчлэх амь аврах хүнс хийдэг Эдэсиа Нүтришн (Edesia Nutrition)-д 5 сая доллар хандивлажээ. Дэлхий дахины эдгээр томоохон төслөөс гадна Сүм дэлхий даяар хэрэгжүүлж буй орон нутгийн хүчин чармайлтыг дэмждэг. Тухайлбал Тонга улсын Боловсрол, сургалтын яамнаас гаргасан сургуулиудад зориулсан үнэ төлбөргүй өглөөний хоол олгох хөтөлбөрт хандив өргөдөг төдийгүй



“Христийн сүмд өлссөн хүмүүсийг хооллохоос илүү хүмүүнлэгийн үйлс гэж байхгүй. . . .
Бид хамтдаа үйлчилснээр Христийн хайрын мутрын хүрэх хязгаарыг тэлдэг.”

—КАМИЛЛ Н.ЖОНСОН, ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧ¹¹

энэ хөтөлбөр Тонгатапу болон Тонгагийн зах хязгаарын арлууд даяар ойролцоогоор 21,000 сурагчид хүрч үйлчилдэг байна.

Хүнсний хомсдолыг шийдвэрлэхэд бие даах чадвар

Бие даах чадварын зарчмууд нь хувь хүмүүст өөрийгөө болон бусдыг тэжээн тэтгэх, сэтгэцийн эрүүл мэндээ сайжруулах, нийгмийн харилцаагаа бэхжүүлэх боломжийг олгодог. Ийм учраас Сүм эдгээр зарчмыг баримталдаг олон улсын хөтөлбөр, байгууллагуудтай хамтран ажилладаг.

Сүм Унгар улсад зовж зүдэрч байгаа гэр бүлүүдэд гахайн фермээ байгуулахад нь тусалдаг Бодва Валли Вүмэнс Рома Ассоциэшн (Bodva Valley Women's Roma Association)-ийн төсөлд хувь нэмрээ оруулжээ. Энэ төсөл нь 100 орчим хүнд хоол хүнсээ бэлтгэн, өөрсдийгөө тэжээх, бүс нутагтаа хүнсний хангалтгүй байдлыг бууруулах боломжийг олгоно.

Сүм Гана улсад хөдөө аж ахуйн сургалт явуулж, фермийн аж ахуйн тоног төхөөрөмжөөр хангах Олон улсын хөгжлийн байгууллага (International Development Enterprise)-ын төслийг санхүүжүүлжээ. Энэ нь гэр бүлүүдэд өөрсдийгөө тэжээн тэтгэж, урт хугацааны бусад хэрэгцээгээ хангахын тулд илүү гарсан ургацаа борлуулахад тусалдаг. Хөтөлбөрт оролцогч Шэй хураасан ургацаа зарж борлуулан, аажмаар хүүхдүүдээ болон орон нутгийнхаа өөр нэг хүүхдийг сургуульд нь буцааж оруулж чадсан байна.

Сүм түүнчлэн орон нутагтаа газар тариалан эрхлэх дадал хэвшлийг сайжруулахаар хөдөө аж ахуйн чиглэлээр боловсрол эзэмшихэд нь Сүмийн гишүүдэд туслахын тулд Бэнсоны нэрэмжит тэтгэлгийг олгосоор байгаа.

Хулиод хүчин чадавхаа бүрэн ашиглахад тусалсан нь

Хулио Гватемалд дутуу төрсөн ба хоол тэжээлийн архаг дутагдалд орсон байлаа. Ээж нь түүнийг Сүмийн хүүхдийн хоол тэжээлийн шинжилгээнд авч явсан бөгөөд түүнд хөхөөр дамжуулан хүүдээ дамжуулах шим тэжээлийн нэмэлт бэлдмэл өгчээ. Хулио зургаан сар хүрээд шууд өөрөө идэх шим тэжээлийн нэмэлт бэлдмэл авчээ. Хулио одоо дөрвөн настай, хоол тэжээлийн архаг дутагдлыг даван туулсан бөгөөд тун удахгүй хэвийн жиндээ орох болно. Хүүхдийн хоол тэжээлийн хүчин чармайлтын ачаар Хулио одоо оюун санаа, бие махбодын хувьд бүрэн өсөж хөгжих илүү боломжтой болжээ.



НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилтан Угандагийн зүүн хойд хэсгийн ган гачигт нэрвэгдсэн бүс нутгуудад хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлыг илрүүлэхээр бугуйн тойргийг хэмжих наалт ашиглаж байгаа нь. НҮБ-ийн Хүүхдийн сангийн гэрэл зураг.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа хүнсний хангамжид сайн дураараа ажилла.
- Жимс ногоо тарьж, ургацаа хөршүүдтэйгээ хуваалц.
- Орон нутгийнхаа хүмүүсийг тойргийнхоо бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт урь.



Орон байрны дэмжлэг

Байгалийн гамшиг, зөрчил мөргөлдөөн гэх мэт сорилт бэрхшээлийн дараа олон хүн толгой хоргодох газаргүй болдог. Сүм хүмүүсийг эдгээр хүнд нөхцөлөөс ангижрахад нь туслахын тулд дэлхий даяарх орон сууцжуулах ажлыг дэмжиж, хувь хүмүүсийг байнгын орон сууцанд шилжүүлэх, шинэ орон байр барих, бизнес барьж байгуулах, тохижуулах тал дээр итгэл даасан байгууллагуудтай хамтран ажилладаг.



Мексикт хандиваар босгосон түр хоргодох майхнуудад амьдарч буй дүрвэгчид.

Зөрчил мөргөлдөөнөөс дүрвэсний дараа орон байр олох нь

Дэлхий даяар олон хүн зөрчил мөргөлдөөнөөс зугтан гэр орноо орхих шаардлагатай тулгардаг. Орон байр хийгээд үндсэн хэрэгцээнүүд нь хангагдаагүй тохиолдолд энэ нь тэдний сэтгэцийн эрүүл мэнд, боловсрол, ажиллах чадвар болон амьдралын бусад хүчин зүйлсэд ноцтой хохирол учруулдаг. Сүм Камеруны Минавао дүрвэгчдийн хуаранд ирж буй дүрвэгчдийг майхан гэх мэт зайлшгүй хэрэгцээтэй зүйлсээр хангах Шэлтэр Бокс (ShelterBox)-ын ажлыг дэмжжээ. Энэхүү дэмжлэг нь зөвхөн унтах аюулгүй газрыг санал болгоод зогсохгүй, гэр бүлүүд хамтдаа байж, амьдралаа дахин төвхнүүлэх гэр орныг бий болгожээ.

Байгалийн гамшигын дараах сэргээн босголт

Байгалийн гамшигын дараа үүнд нэрвэгдсэн хүмүүс хог хаягдлыг цэвэрлэхээс эхлээд гэр орноо сэргээн босгох, тохижуулах зэрэг урт зам туулах хэрэгтэй болдог. 2024 оны 2-р сард Чилийн Күилпүэ, Вилла Алэмана, Виня дэл

Мар суурин газруудад асар том гал гарсан нь сүүлийн арван жилд Чилид гарсан хамгийн хор хөнөөлтэй түймэр болсон юм.

Сүм Дэсафио Лэвантэмос Чили (Desafío Levantemos Chile) сантай хамтран оршин суугчдад зориулан барилгын болон гэр ахуйн тавилга худалдаж авахад туслах хэдэн зуун бэлгийн картыг санхүүжүүлжээ. Эдгээр бэлгийн карт нь хүмүүст амьдралаа дахин төвхнүүлэх боломжийг олгосон санхүүгийн нэн чухал тусламж болсон аж.

Түр хоргодох байранд гэр орноо төвхнүүлэх нь

Нэг шөнө Калтуми бага насны хүүхдүүдээ дагуулан, өмссөн хувцаснаасаа өөр юу ч авалгүй аюулгүй байдлын төлөө гэрээ орхин зугтахаас өөр аргагүй болов. Минаваогийн дүрвэгчдийн хуаранд эсэн мэнд хүрч ирснийхээ дараа Калтуми гэр бүлдээ Сүмийн болон Шэлтэр Боксын дэмжлэгтэйгээр жижигхэн майхантай болжээ. Майхан тэдний гэр болсон бөгөөд Калтуми одоо хүүхдүүдээ хооллохын тулд майхныхаа гадаа газрын самар, хүнсний ногоо ургуулдаг болжээ.

“Би ногоо тарих ажилд дуртай. Яагаад гэвэл энэ нь хэнээс ч хамааралгүйгээр гэр бүлээ тэжээхэд тусалдаг юм” гэж тэр хэлэв. Хоргодох байр нь түүнд гэр бүлийнхээ амьдралыг шинээр эхлүүлж, бие даах чадвартай болох боломжийг олгосон юм.

Би юу хийж чадах вэ?

- Хэн нэгэнд дээврээ засах эсвэл солиход нь тусал.
- Орон гэргүй хүмүүсийг асрах байранд сайн дураараа үйлчил.
- Хуучин тавилгаа хэрэгцээтэй гэр бүлд хандивла.



Сэтгэцийн эрүүл мэнд

Сэтгэцийн болон сэтгэл санааны бэрхшээл нь хүмүүсийн баяр баясгаланг мэдрэх, Бурхантай болон бусадтай харилцах, өөрийн үнэ цэнтэй байдалд итгэх чадварыг хязгаарладаг. Сүм эдгээр бэрхшээлтэй тулгарч буй хувь хүмүүст илүү их тайвшрал, итгэл найдвар, сэтгэлийн хаттай болоход нь туслах хэд хэдэн хөтөлбөр, эх сурвалжуудыг санал болгодог.

Гэр бүлд туслах байгууллага

Сэтгэц, сэтгэл зүй, зан төлөвийн асуудалтай тулгарч байгаа Сүмийн гишүүд бишоптоо Гэр бүлд туслах байгууллагаас тусламж авах хүсэлт гаргаж болно. Тухайн гишүүнтэй зөвлөлдсөний үндсэн дээр орон нутаг дахь үйлчилгээ үзүүлэгчдэд хандах, өөртөө туслах эх сурвалж санал болгох, Гэр бүлд туслах байгууллагын ур чадвар олгох сургалт, бүлгийн сэтгэл засал, ганцаарчилсан зөвлөгөөнд үнэ төлбөргүй хамруулах зэрэг зохих эх сурвалжуудыг олж тогтоодог.

Гэр бүлд туслах байгууллага бас дараах зүйлсийг санал болгодог. Үүнд:

- ◆ Номлогчдод зориулсан зөвлөгөө
- ◆ Удирдагчдад зориулсан тусламжийн утас
- ◆ Сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх сургалт, хөтөлбөр
- ◆ Сэтгэл санааны хувьд өөртөө туслах дасгал ажлын материал

Донтолтоос ангижрах хөтөлбөр

2024 онд Сүмийн Донтолтоос ангижрах хөтөлбөр нь Аврагчийн эдгээх хүчийг тусгах үүднээс *Аврагчаар дамжуулан эдгээх: Донтолтоос ангижрах хөтөлбөр* гэсэн нэртэй болж өөрчлөгдсөн. Энэхүү үнэ төлбөргүй, нууцлал бүхий хөтөлбөр нь донтолт хийгээд хянахад хэцүү зан авиртайгаа тэмцэж байгаа Сүмийн гишүүд болон бусад хүнд дэмжлэг үзүүлдэг. Энэ нь шинэчлэгдсэн *12 алхамт хөтөлбөрийн удирдамж* зэрэг эх сурвалжуудаас гадна донтолтоос ангижирч байгаа хүмүүсийн гэр бүлийнхэнд туслалцаа үзүүлдэг.

Бусад сэтгэцийн эрүүл мэндийн эх сурвалжууд

Сүм Их Эзэнээр дамжуулан хүч чадлыг олж авах нь: Сэтгэлийн тэнхээтэй байх хичээл зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тусламж эрэлхийлж буй Сүмийн гишүүд болон бусад хүнд туслах нэлээд хэдэн эх сурвалжийг санал болгодог. 2024 онд гарсан нэмэлт эх сурвалжуудад дараах зүйлс орно.

- ◆ **Сэтгэл зүйн тусламжийн картууд:** Эдгээр карт нь хүмүүст өөрсдийн сэтгэл санааны бэрхшээлийг хэрхэн зохицуулж, бусдыг дэмжих талаар зөвлөдөг.
- ◆ **Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх веб хуудас:** Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар шаналж буй хүмүүст туслах хэрэглэгдэхүйц удирдамж заавар.

“Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн.”

—ГАЛАТ 6:2

Аврагчаар дамжуулан эдгээх

Аврагчаар дамжуулан эдгээх: Донтолтоос ангижрах хөтөлбөр дээрх эх сурвалжуудын ачаар Лизи донтолтоо даван туулж, амьдралын чанараа сайжруулан урагшилжээ. Энэхүү хөтөлбөрийн 12 алхам бүхий үйл явц нь хүмүүст асуудалтайгаа нүүр тулж, бусадтай холбогдож, Есүс Христийн Цагаатгалыг илүү сайн ойлгоход тусалдаг. Лизи одоо эрүүл саруул, хоёр хөөрхөн хүүхэдтэй болсон ба донтолтыг даван туулахад нь бусдад дэмжлэг үзүүлэхийг хичээж байна.

Би юу хийж чадах вэ?

- Танай бүсэд донтолтоос ангижрах бүлэг байхгүй бол орон нутгийнхаа удирдагчдаасаа бүлэг үүсгэхийг хүс.
- Боломжтой бол гэрчилгээ олгох сургалтаар дамжуулан сэтгэл зүйн анхны тусламжийн талаар сурч мэд.
- Орон нутгийнхаа хурал цуглаанууд дээр сэтгэцийн эрүүл мэндийн талаар яриа өрнүүлэхээр сэтгэл зүйн тусламжийн карт ашиглах талаар бодож үз.



Бие даасан байдал

Сүм хүн бүрийг бие даах чадвартай болж, гэр бүл, олон нийтээ халамжлах чадвараа дээшлүүлэхэд туслахыг эрэлхийлдэг. Бие даах чадвар нь нэр төрийг өндөрт өргөж, чадавхаа бүрэн ашиглахад тусалдаг.

Бие даах чадвар хөгжүүлэх бүлэг

Хувь хүмүүсийг бие даахад нь туслахын тулд Сүм хэд хэдэн хичээлийг санал болгодог. Үүнд:

- ◆ Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь
- ◆ Хувийн санхүүгээ зохицуулах нь
- ◆ Сэтгэлийн тэнхээ
- ◆ Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь
- ◆ Бие даасан байдлын төлөө илүү сайн ажилтай болох нь

Францын Парис хотод гадасны нэг ерөнхийлөгч гадасныхаа удирдлагын сургалтыг явуулж, тойрог бүрийг халамж ба бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтнийг дуудахад уриалжээ. Эдгээр зохицуулагч бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдийг хэрхэн удирдан явуулах талаар сурч, бүсийнхээ олон хүнийг бие даах чадвартай болох замд хөтөлсөн аж.

Нэг хос Хувийн санхүүгээ зохицуулах болон Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх бүлгүүдэд хамрагдсан сэтгэгдлээ ийн илэрхийлжээ. “Бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүд болон ангиуд нь бидэнд сүнслэгээр нөлөөлж, ‘хүчин чадавхаа сэргээж, өргөжүүлэхэд’ тусалдаг. [Бид] эдгээр ангид хамрагдсандаа баяртай байдаг. Таван жил өнгөрсөн ч [бид] үүнээс ирэх адислалуудыг өдөр бүр харсаар байна.”

Бие даах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн ажлууд

Сүм Либерид хөдөө аж ахуйн сургалт, тариаланчдын хамтын ажиллагаа, хөдөө аж ахуйн бизнес төвүүд зэрэг Дэлхийн хүнсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд хандив өргөжээ. Эдгээр хөтөлбөр нь Либерийн тариаланчдад газар тариалангийн арга барилаа сайжруулах, ургацаа нэмэгдүүлэх, орлогоо ихэсгэх талаар заасан аж. Түүнээс гадна Сүм төв, агуулахууд барих ажлыг санхүүжүүлснээр тариалангийн аж ахуйн үр ашигтай байдлыг дээшлүүлж, олон нийтэд тусалсан байна.

Сүм Бразилд португал хэлний сургалтыг дэмжсэн бөгөөд уг сургалт нь цагаачдад ажлын боломжоо дээшлүүлэхэд нь тусалжээ.


Бие даах чадвар хөгжүүлэх ангиар дамжуулан хүчирхэгжсэн нь

Хуанита Сүмийг олж, Сүмд нэгдэх хүртлээ гурван жилийн турш гэр оронгүй байжээ. Удалгүй тэрээр Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь бие даах чадварын хичээл авч, “Тэр цагаас хойш миний амьдрал өмнөх шигээ байхаа больсон” гэж хэлэв.

Дараа нь Хуанита Хувийн санхүүгээ зохицуулах нь болон Сэтгэлийн тэнхээ хичээлд хамрагдсан байна. “Хичээл бүр надад миний талаар ямар нэг зүйлийг заасан” гэж тэр хэллээ. Хуанита одоо дээд сургуульд хамрагдаж, төлбөрөө төлөх боломжтой болж, яваандаа хүний нөөцийн салбарт ажиллахыг зорьж байна.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт нэгд.
- Хичээл зааж, ур чадвараа хуваалц.
- Бие даасан байдлыг дэмждэг төслүүдэд сайн дураараа оролц.



Хөдөлмөр эрхлэлтийн төвд ажил хайж буй эмэгтэй.



“Залуу хүмүүс, гэр бүлүүд тэтгэмж бус дэмжлэг хүсэж байна.”

—БЭРРОН СЭГАР, АНУ-ЫН ДЭЛХИЙН ХҮНСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ¹²



Цагийн зүүний дагуу дээрээс доошоо: Либериd тариаланчид хамтын тариалангийн талбайгаа усалж байгаа нь. Тонгад амьдардаг нэг эмэгтэй өөрийн дэлгүүрт бараа зарж байгаа нь. Муслим Эйд (Muslim Aid)-тэй хамтран Босниагийн иргэдэд зөгийн үүр болон зөгий үржүүлэх талаар боловсрол олгож байгаа нь. Халамжийн нийгэмлэгийн эгч нар орон нутгийнхаа хүмүүст уншиж, бичихийг зааж байгаа нь.





Дэлхий даяар ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖ

“Хэрэв бид бүгдээрээ Аврагчийн хайрлах, үйлчлэх үлгэр жишээг үнэхээр дагах юм бол, өөрсдөөсөө тэс өөр гэж боддог хүмүүсийг хувьдаа үнэхээр таньж мэдэх юм бол . . . бид үнэхээр Христ дотор нэг болох болно.”

—Ж.АНЭТТ ДЭННИС,
ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭГДҮГЭЭР ЗӨВЛӨХ¹³



Илүү ихийг мэдэхийг хүсвэл кодыг уншуул.



Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын сурагчид НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгээр байгуулсан зөвлөгөө, хөгжлийн төвд тоглож байна. НҮБ-ийн Хүүхдийн сангийн гэрэл зураг.

Африк

Бидний зорилго бол хүмүүст үндсэн хэрэгцээгээ хангаж, бие даах чадвараа хөгжүүлж, орон нутгаа хүчирхэгжүүлэхэд нь туслах явдал юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд Сүм Африк даяарх иргэдийг хоол хүнс, боловсрол, цэвэр ус болон бохирын системээр хангахад дэмжлэг үзүүлжээ.

Хоол хүнс, цэвэр усны хүртээмж

Сүм Дэлхийн усны өдрөөр Нигерийн Мбоши Ажи нутагт 10,000 литрийн багтаамжтай моторт цооног болон ариун цэврийн шинэ байгууламжийг хандивласнаа зарласан. Нигерийн ВатэрЭйд (WaterAid)-тэй хамтарсан уг төсөл олон нийтийг цэвэр усаар хангаж, тэдэнд ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой байдлыг сурталчлан таниулсан юм.

Сүм Зимбабве дахь Зимбури бага сургуулийн цэвэр усны хүртээмжийг эн тэргүүнд тавьж, усны шинэ систем суурилуулсан байна. Шинэ систем суурилуулснаар охидод шүршүүрт орох боломж бүрдэж, сургуулийн цэцэрлэг хангалттай устай болсон нь сар бүрийн хичээл таслалтыг бууруулсан гэж сургуулийн захирал, багш нар онцлон тэмдэглэжээ.

Боловсрол

Гана улсад Фоасэ сургуулийн сурагчдад илүү олон анги танхим төдийгүй хэвийн үйл ажиллагаатай ариун цэврийн өрөөнүүд хэрэгтэй байлаа. Сүм 1,000 орчим сурагчид зориулсан 10 анги танхим, ариун цэврийн өрөө байгуулж өгч, усны цооног гаргажээ. Түүнээс гадна, Сүм усыг унданд хэрэглэх боломжтой болгохоор ус шүүлтүүрийн систем суурилуулжээ. Эдгээр сайжруулалт нь сурагчид, ажилтнуудад илүү аюулгүй орчныг бүрдүүлж, сурагчдын ирц нэмэгдсэн юм.

Сүм бас бага насны хүүхдийн боловсролд төвлөрсөн НҮБ-ийн хүүхдийн сангийн төсөлд хувь нэмрээ оруулж, боловсролын санаачилгад дэмжлэг үзүүлжээ. Уг хүчин чармайлт нь сургууль завсардсан 6,000 хүүхдийг сургалтын өөр хувилбар болон хоцрогдол арилгах хөтөлбөрт хамруулж, 140,000 хүүхдэд чанартай боловсролын хөтөлбөрүүдэд хамрагдах боломж олгосон юм.

“Дэлхий даяар 2.2 тэрбум гаруй хүн цэвэр ус болон бохирын систем хангалтгүй нөхцөлд амьдарч байна. Энэ нь дэлхий даяарх хүмүүс болон засгийн газруудын хувьд хурцадмал байдлын суурь шалтгаан болж байна. Цэвэр ус болон тогтвортой бохирын системийн хэрэгцээг таниулах зорилгоор Дэлхийн усны өдрийг жил бүр тэмдэглэдэг.”

—СОЛОМОН АКПАНУФОТ, НИГЕРИЙН ЭНУГУ ДАХЬ ВАТЭРЭЙДИЙН ЗОХИЦУУЛАГЧ¹⁴





Зүүн талд: Либерид нэгэн эмэгтэй тосгоны худгаас цэвэр ус авч байгаа нь. **Баруун талд:** Эх баригчид Хөүп (HOPE) төслийн Сьерра Леоне дахь Сүмтэй хамтран зохион байгуулсан Нярай хүүхдэд амьсгалахад туслах сургалтад хамрагдаж байгаа нь.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба тусгай хэрэгцээ

Ганагийн Нвинса хотод орон нутгийн засаг захиргаа эмнэлэг барьж дуусгасан ч эмнэлгийн ажилтнуудад түрээслэх өрөө ойр орчимд нь байсангүй. Сүм энэхүү хэрэгцээг шийдвэрлэхийн тулд сувилагчдын байр барьж, эмнэлгийн ажилтнуудыг аюулгүй амьдрах газартай болгожээ. Уг барилгыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр тоноглож, хандивын тоног төхөөрөмжийг ашиглахад зайлшгүй шаардлагатай цахилгааны системээр хангасан байлаа.

Мали улсад Сүмийн хандиваар дэлхий даяарх эхчүүд, хүүхдүүдэд аюул учруулж буй өвчин болох эх, нярайн татран (MNT)-ийн тархалтыг амжилттай арилгахад нь НҮБ-ийн хүүхдийн санд тусалжээ. Эх, нярайн татран өвчин нь жил бүр хэдэн арван мянган нярайн амь насыг авч оддог бөгөөд эмчилгээ хийлгэх газар олдохгүй тохиолдолд тус өвчнийг туссан бараг бүх нярай энддэг. Энэ нь уг өвчин тархсан улс орнуудын эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна. Мали улс эх, нярайн татран өвчнийг үгүй хийхэд амжилт гаргасан нь тус улсын удирдлага, НҮБ-ийн Хүүхдийн сан зэрэг хэд хэдэн итгэл даасан байгууллагуудын хамтын хүчин чармайлтын нотолгоо юм.

Зөрчил мөргөлдөөний дараа хүнсний аюулгүй байдлыг хангасан нь

Надиа саяхан зөрчил мөргөлдөөний улмаас Өмнөд Суданд буцаж ирсэн бөгөөд буцаж ирсэн хүмүүсийн тоо огцом өссөн нь хүмүүнлэгийн яаралтай хэрэгцээг бий болгосон аж. КЭЙР (CARE) болон Сүмийн хамтын ажиллагааны ачаар Надиа болон өөр 1,300 өрх дасан зохицоход туслах, зайлшгүй шаардлагатай хүнсний нөөцийг хүлээн авчээ. Одоо Надиа гэр бүлээ дараагийн гурван сарын турш хоол хүнсээр хангаж чадахаар боллоо.

“Гэр бүлдээ хоол хүнсгүй Суданаас буцаж ирсэн нь биднийг цөхрөлд оруулсан юм. Энэ тусламж асар их тайтгарлыг өгсөн” гэж Надиа хэлэв.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа ус, бохирын систем, эрүүл ахуйн талаар илүү ихийг мэдэж ав.
- Орон нутгийнхаа хүнсний хангамжийн газартай шаардлагатай байгаа хэрэгцээнийх нь талаар ярилц.





Японд амьдардаг нэгэн эмэгтэй хүүхдүүддээ ном уншиж өгч байна.

Ази

2024 онд Ази тив даяар олон тооны байгалийн гамшиг болж, хүмүүст хүмүүнлэгийн тусламж хэрэгтэй болсон. Сүм болон Сүмийн гишүүд эдгээр байгалийн гамшигт өрөвч сэтгэл, хайраар хариу арга хэмжээ авч, орон нутгийнхандаа тусламж үзүүлсэн юм. Түүнээс гадна Сүм энэ бүс нутаг дахь бие даасан байдлыг дээшлүүлэхийн тулд боловсрол, эрүүл мэндийн салбарыг голчлон анхаарсан билээ.

Боловсрол

Сүм Монголд хөдөө орон нутгийн дунд сургуулиудыг компьютероор хангах төслийг дэмжжээ. Сүм Боловсролын Яамтай хамтран Монголын баруун аймгийн дунд сургуулиудад 1,000 ширхэг компьютер хүргүүлсэн аж. Энэ төсөл ойролцоогоор 43,000 сурагчид боловсрол эзэмших боломж олгож адисалсан билээ.

Камбож даяар олон сурагч чанартай боловсрол эзэмших боломжгүй байдаг. Сүм 2024 онд сурагчдад илүү аюулгүй, тогтвортой суралцах орчныг бүрдүүлэх зорилгоор нэлээд хэдэн барилгын болон засварын төслийг санхүүжүүлсэн. Эдгээр төсөлд хэт дүүргэлтийг багасгахын тулд шинэ анги танхим байгуулах, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн тулд барилга байгууламжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хэрэгтэй барилга байгууламжуудыг засварлах зэрэг ажил багтсан.

Эрүүл мэнд ба цэвэр ус

Сүм 2024 онд Ази тивд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, түүний дотор эрүүл мэндийн байгууллагуудыг шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, ус ба бохирын системийн санаачилгуудыг дэмжих ажилд тусламж үзүүлсэн.

Сүм Индонезид сургуульд явах, гэр бүлээ тэтгэх, нийгэмдээ идэвх оролцоотой байх зэрэгт нь хүмүүст туслахын тулд доод мөчдийн протез хандивлажээ.

Тимор-Лэстэд Сүм алслагдсан тосгодод нэн шаардлагатай ус хүргэх төсөл дээр ажилласан байна. Эдгээр тосгонд амьдардаг хувь хүмүүс болон гэр бүлүүдийг дэмжихийн тулд усны нөөцийн сав худалдан авчээ. Энэ хүчин чармайлт нь усны хүртээмж дутмаг хүмүүсийн амьдралын чанарыг ихээхэн сайжруулсан юм.

Онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх

Сүмийн гишүүд байгалийн янз бүрийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст яаралтай тусламж үзүүлж байхдаа “нэг нэгнийх нь ачаа хөнгөн байж болохын тулд . . . гашуудах тэдний хамт гашуудах . . . тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах[ыг]” (Мозая 18:8–9) хичээдэг.

4-р сард Индонезид Руанг галт уул дэлбэрсэн. Үүний хариуд Сүм орон нутгийн засгийн газар болон бусад байгууллагатай хамтран нүүлгэн шилжүүлсэн 3600 орчим хүнийг орон байр, хувцас хунар, бусад хэрэгцээт зүйлсээр хангасан байна.

Азийн бусад хэсэгт ч мөн өнгөрсөн жилийн турш байгалийн гамшиг болсон. 1-р сард Японы Ното хойгийг сүйрүүлсэн газар хөдлөлтийн үед Сүм түүхэн дурсгалт газруудыг хадгалж үлдэхэд тусалж хандив өгчээ. Хандив нь уг бүс нутаг дахь шашны ариун сүм дугануудыг сэргээн засах зардалд тусалсан байна. Сүмийн гишүүд бас газар хөдлөлтөд сүйдсэн суурин газруудыг цэвэрлэхийн тулд эцэж цуцахыг үл мэдэн ажилласан юм.





Зүүн талд: Өмнөд Солонгост үйлчилж буй номлогчид нэг хүнд шинэ байранд ороход нь тусалж байгаа нь. **Баруун талд:** Монгол хүүхдүүд сургууль дээрээ хандивын компьютеруудыг ашиглаж байгаа нь.

Гэр орон, амьдралаа сэргээн босгосон нь

Малайзын зүүн хэсэгт болсон үерийн улмаас Милагийн* гэр маш их эвдэрчээ. Мила хөршүүдийнхээ нэгэн адил гэр бүлийнхээ хамтаар ус татарсны дараа хог хаягдлуудыг цэвэрлэж, амьдралаа дахин төвхнүүлж эхэлжээ. Милагийн ор зэрэг гэр ахуйн олон эд зүйл нь алга болсон эсвэл эвдэрч сүйдсэн байв. Мила Сүмээс тараасан хандивын нэг хэсэг болох гудас, ор дэрний хэрэгсэл хүлээн авчээ. Мила амьдралаа төвхнүүлэх гэж зүдэрсний эцэст аюулгүй, цэвэр цэмцгэр толгой хоргодох газартай болсон юм.

**Нэрийг өөрчлөв*

“Бид бүгд нэг нэгэндээ тусалдаг ах, эгч, дүүс билээ. Бид Сүмээс тэрхүү хайрыг мэдэрдэг. Сэргээн засварласан барилгууд үзэсгэлэнтэй. Өвчтөнүүд энд эмчилгээ сувилгаа хийлгэж байгаадаа баяртай байдаг. Эмнэлгүүд одоо илүү цэвэрхэн болж, ариун цэвэр нь сайжирсан.”

—ХЭ НЭК БАН ХЭН, КАМПОН ТОМ ХОТЫН ОРЛОХ ЗАХИРАГЧ¹⁵

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа сургуульд сайн дураараа давтлага өг.
- Оршин суугаа газрынхаа хүнд хэцүү нөхцөлд байгаа гэр бүлд хоол хийж өг.
- Орон нутгийнхаа түр хоргодох байранд цэвэрлэгээний материал хандивла.



Австрали, Филиппин, Номхон далайн бүс нутаг

Сүмийн Номхон далайн бүс нутагт үзүүлдэг хүмүүнлэгийн тусламж ихэнхдээ галт уул, хар салхи, үер зэрэг байгалийн гамшигтай холбоотой байдаг. Түүнчлэн Сүм нь хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах, цэвэр усаар хангах зэрэг бүс нутгийн бусад хэрэгцээг шийдвэрлэхийн тулд ижил зорилготой байгууллагуудтай хамтран ажилладаг.



Шинэ Зеландын залуучууд болон номлогчид байшингуудыг сэргээн босгоход сайн дураараа оролцож байна.

Онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх

Шинэ Зеландын Хойд арлын олон оршин суугч 2023 онд арлыг сүйтгэсэн Габриэл хар салхины хор нөлөөг одоо ч амссаар байна. Энэхүү байгалийн гамшгаас үүдэлтэй бэрхшээлүүдийг хөнгөвчлөхийн тулд Сүм гамшигт нэрвэгдсэн Ваироа хотынхонд орон байр дахин барихад тусалсан юм.

Сүм Филиппиний Баруун Нэгрост Канлаон галт уул дэлбэрсний дараа нүүлгэн шилжүүлэгдсэн 80 гаруй гэр бүлд хүнсний багц, ундны ус, ор дэрний хэрэгсэл, ариун цэврийн хэрэгсэл зэргийг тараажээ.

Хүүхдийн хоол тэжээл

Дэлхий даяарх хүүхдүүдэд өсөж торнин оюун санаа, бие махбод, сүнслэг байдлын хувьд хүчин чадавхдаа бүрэн хүрэхэд нь туслах үүднээс Сүм дэлхий даяар хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах ажлыг эн тэргүүнд тавьдаг. Энэ нь орон нутгийн олон хандив энэ ажлыг дэмжиж байгаа Филиппин улсын хувьд онцгой ач холбогдолтой юм. Сүмийн хүрээнд хоол тэжээлийн дутагдалд орсон хүүхдүүдэд зориулсан орон нутгийн хүнс тэжээлийн санаачилгуудаас гадна Сүм Тонгагийн Боловсролын

яамтай хамтран хоол тэжээлийн дутагдалд өртөх эрсдэлтэй 168 сургуулийн хэдэн мянган сурагчийг өглөөний хоолоор хангадаг.

Цэвэр ус

Сүм Номхон далайн бүс нутаг дахь хүмүүнлэгийн төслүүдэд хэдэн сая доллар хандивласнаар НҮБ-ийн Хүүхдийн сан Вануату, Соломоны арлууд, Папуа Шинэ Гвинейд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Түүнээс гадна, Сүм Папуа Шинэ Гвиней дэх сургуулиудын усны барилга байгууламжийг сайжруулах ВатэрЭйд (WaterAid) төслийг санхүүжүүлсэн юм.

Хөгжлийн үе шатууддаа хүрсэн нь

Филиппиний Пампанга хотод тухайн үед дөрвөн настай байсан Амара охин Сүмээс зохион байгуулсан орон нутгийн хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн үеэр үзлэг шинжилгээнд оржээ. Үзлэгийн үр дүнд Амара хоол тэжээлийн дутагдалд өртсөн нь илэрсэн аж. Түүнийг бичил тэжээлийн нунтаг бодис, нэмэлт витамин болон эм бэлдмэлээр эмчилжээ. Тэжээлийн дутагдлыг нь арилгах зорилгоор түүний хоолыг ч мөн шимт бодисоор баяжуулж байв. Үүнээс гадна Амарагийн эцэг эхэд зохих шим тэжээл, эрүүл ахуйн дэг журам, хүүхэд асрах талаар мэдлэг олгосон ба гэр бүл нь цэвэр ус хэрэглэх, эрүүл мэндийн тусламж авах илүү боломжтой болжээ.

Эдгээрийн ачаар Амарагийн эрүүл мэнд аажмаар сайжрав. Одоо тэр өөрийнхөө насны хэвийн жинд орсон бөгөөд хөгжлийн чухал үе шатандаа хүрсэн байна.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутагтаа тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах боломжийг олж хай.
- Хүүхдүүдээ тэжээллэг өглөөний хоол идэхэд нь тусал.
- Хүүхдэд гараа хэрхэн угаахыг зааж өг.



Карибын тэнгисийн орнууд

Сүм 2024 онд Карибын тэнгисийн орнуудын сурагчдад “судалж мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэх[эд]” (Сургаал ба Гэрээнүүд 88:118) туслах боловсролын санаачилгуудыг дэмжсэн юм. Сүм болон Сүмийн гишүүд түүнчлэн тусламж хэрэгтэй хүмүүст эрүүл мэндийн болон онцгой байдлын тусламж үзүүлэхэд анхаарлаа хандуулсан.

Боловсрол

Сүм Карибын тэнгисийн орнуудын багш, сурагчдад орчин үеийн суралцах орчин бүрдүүлж өгөх төслүүд дээр ажилласан байна. Жишээлбэл: Суринамын Парамарибо дахь Сүмийн гишүүд орон нутгийн гурван сургуулийг засварлаж, суралцах илүү сайн орчныг бий болгожээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Хувь хүмүүсийн эрүүл мэндэд санаа тавих нь тэдэнд бие даах чадвартай болж, бусдыг халамжлах боломжийг олгодог. Сүмийн хандив тусламжаар Чэрити Вишн (Charity Vision) байгууллага нь Бүгд Найрамдах Доминикан Улсын мянга мянган сурагчийг хараа зүйн үзлэгт хамруулжээ. Шаардлагатай тохиолдолд тэдгээр сурагчид нүдний шил өгсөн нь тэдэнд сургууль болон сургуулиас гадуур суралцах илүү сайн туршлага өгчээ.

Онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх

Бэрл хар салхины улмаас олон газар гамшигт нэрвэгдсэний дараа ойролцоох газруудаас ирсэн Сүмийн гишүүд хоол хүнс, эрүүл ахуйн иж бүрдэл зэрэг нэн шаардлагатай зүйлсийг хүргэж өгөхөөр Юнион арал руу очжээ. Гишүүд хар салхинаас үүдсэн хог хаягдлыг замаас цэвэрлэхийн тулд бусад байгууллагатай хамтран ажиллав.



Ямайкийн залуучууд үйлчлэлийн төсөл хамтран төлөвлөж байгаа нь.

Чанартай боловсрол олгох нь

Ямайк дахь Гарви Масэо ахлах сургуулийн Хөдөө аж ахуйн тэнхимийн эрхлэгч, хатагтай Винсэнт техникийн болон мэргэжлийн хичээл заах тусгай тоног төхөөрөмж хүлээн авчээ.

Хатагтай Винсэнт хандивын талаар хэлэхдээ, “Бид эдгээр бэлгийг харж хандахаа амлаж байна. Тэдгээрийг ашиглах явцдаа биднийг ийн адисалсанд талархах болно” гэжээ. Одоо түүний сурагчид хандивын тоног төхөөрөмжөөр зөгийн бал үйлдвэрлэж, бие даах чадвартай болж, ирээдүйн гэр бүлээ тэжээхэд ашиглах ур чадварт суралцаж байна.

Би юу хийж чадах вэ?

- Хүүхэдтэй хамт ном унш.
- Эмчид үзүүлэх хэрэгтэй байгаа хүнийг хүргэж өг.
- Олон нийтийн цэвэрлэгээний ажилд тусал.

“Бидэнд тусламж хэрэгтэй үед Тэр биднийг тусламж хэрэгтэй хэн нэгэн рүү чиглүүлдэг. Тийн бид Түүний тусламжийг бусдад үзүүлэх үедээ Түүнээс өөрсдөө тусламж авдаг.”

—КРИСТИН М.ЕИЙ, ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ХОЁРДУГААР ЗӨВЛӨХ¹⁶





Гишүүдэд зориулсан Хүүхдийн хоол тэжээлийн ажлын нэг хэсэг болгон эмч хүүхэд жинлэж байгаа нь.

Төв ба Өмнөд Америк

Сүмийн гишүүд байгалийн гамшгийн үед тусламж хэрэгтэй хөршүүдээ гараа сунгадаг. Төв болон Өмнөд Америкт байгалийн гамшгаас болж олон хүн толгой хоргодох байр, хоол хүнс, бусад хэрэгцээт зүйлээр гачигдаж байна. Сүм 2024 онд хүнсний аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэндийн салбарт тусламж үзүүлэх ажлыг эн тэргүүнд тавив.



Гэрэл зургийг Оскар Лэвиа/Католик тусламжийн үйлчлэл (Catholic Relief Services)-ийн Силвэрлайт (Silverlight) хөтөлбөр.

Гамшгийн тусламж

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Бразилын Рио Грандэ до Сул дахь үерт нэрвэгдэгсдэд нэн чухал тусламж үзүүлжээ. Үерийн улмаас 200,000 хүн нүүлгэн шилжүүлэгдэж, 90 гаруй хүн амь насаа алджээ. Сүм 21 хоргодох байр байгуулж, хүнсний багц тарааж, гудас, ариун цэврийн иж бүрдэл зэрэг 6 тонн хэрэгцээт зүйлсийг хүргэж өгсөн байна. Түүнээс гадна Сүмийн гишүүд тусламжийн бараа материалууд хандивлаж, цэвэрлэгээний ажилд оролцсон юм.

Парагвайн Мистолар хотод олон жил үргэлжилсэн ган гачиг усны хомсдолд хүргэв. Сүм орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн борооны усны нөөцийн сав, зөөврийн усны сав суурилуулах ажлыг санхүүжүүлжээ.

Чилид Сүмийн гишүүд нэг нэгэндээ болон аймшигт гал түймэрт нэрвэгдэгсдэд үйлчилж, цуглааны байруудыг хоргодох байр болгон ашиглуулж, хоолны багц болон тусламжийн зүйлс тараан өгчээ.

Хүнсний аюулгүй байдал

Никарагуад Сүм сургуулийн хүүхдүүдийг хоолоор хангах Дэлхийн хүнсний хөтөлбөрт хувь нэмрээ оруулжээ. Төслийн хүрээнд улс орон даяарх сургуулиудын дэд бүтэц, гал тогооны шинэчлэлтийг хийж, сурагчдын суралцах орчныг сайжруулсан байна.

Боловсролын дэмжлэг

Сүмээс Аргентины оюутнуудын тэтгэлэгт зориулж мөнгө хандивласан байна. Каритас План Эмаус (Caritas's Plan Emaús)-ын нэг хэсэг болох эдгээр тэтгэлэг нь улс орон даяарх тусламж хэрэгтэй олон оюутанд ашиг тусаа өгч, ирээдүйд ажиллах боломжийг нь нэмэгдүүлж, бие даах чадвартай болоход нь туслах болно.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

2024 онд тусламж хэрэгтэй хүмүүст өгөөмрөөр цусаа хандивласан гишүүдийн ачаар Сүм Боливийн Ла Пас хотын цусны хандивын аянд гүйцэтгэж буй чухал үүргээрээ олонд танигдсан юм.

Сүм бас Перугийн Даниэл Алсидэс Каррионы Үндэсний эмнэлэг дээрх Оперэйшн Смайл (Operation



Smile) байгууллагын мэс заслын 99 дэх хөтөлбөрийг дэмжиж, уруул, тагнайн сэтэрхийтэй хүүхдүүдэд туслах зайлшгүй шаардлагатай хэрэгслээр хангаж, эмнэлгийн оношилгоонд хамруулсан байна.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа цусны төвд цусаа хандивла.
- Орон нутагтаа үйлчлэх боломжуудыг JustServe.org-оос хайж ол.
- Өөрийн ойролцоох гамшгийн дараах цэвэрлэгээний ажилд оролц.

Цусаа хандивлаж, хайраа илэрхийлэх

Эл Сальвадорын Сан Сальвадор дахь Бэнжамин Блүүмийн Үндэсний Хүүхдийн эмнэлгийн цусны төвийн тэргүүн Доктор Алфарио эмнэлэгт нь цусаа хандивласан Сүмийн гишүүдэд талархал илэрхийлэв.

Сүмийн гишүүд болон найз нөхөд зэрэг зуу орчим донор хөршүүддээ хайраа илэрхийлэн Сан Сальвадор гадасны цусны хандивын аянд оролцжээ. Доктор Алфарио: “Эдгээр . . . хандивын ачаар эмнэлгийнхээ цусны нөөцийг хангаж, наад зах нь 230 хүүхдэд яаралтай тусламж үзүүлж чадсан. Эдгээр нь үнэхээр хайрын илэрхийлэл мөн юм” гэж хэлжээ.

“ . . . Итгэл, үйлчлэл, золиослол бол биднийг өөрсөд дээрээ бага төвлөрч, харин Аврагч дээр илүү их төвлөрөхөд тусалдаг. Бидний үйлчлэл, золиослол илүү өрөвч сэтгэлтэй, итгэлтэй, бусдын төлөө байж, Есүс Христ дотор байх тусам бид Түүний бидэнд зориулсан цагаатгах сэтгэл, ач ивээлийг улам илүү ойлгож эхэлдэг.”

—ГЭРРИТ В.ГОНГ, АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГЫН АХЛАГЧ¹⁷



Хондурасын оюутнууд завсарлагаагаар хоол идэж байгаа нь. Гэрэл зургийг Оскар Лэвиа/Католик тусламжийн үйлчлэл (Catholic Relief Services)-ийн Силвэрлайт (Silverlight) хөтөлбөр.



Европ

Байгалийн гамшиг, улс төрийн зөрчилдөөн нь 2024 онд Европт тулгарсан олон сорилтын зарим нь байлаа. Үүний хариуд Сүм тус бүс нутаг дахь гамшигт нэрвэгдэгчдэд туслах, эмзэг бүлгийн иргэдэд болон хүнсний аюулгүй байдалд анхаарал хандуулсан олон хүмүүнлэгийн төслийг санхүүжүүлж, хамтран хэрэгжүүлжээ.



Швейцар дахь номлогчид хүчтэй шуурганы дараа цэвэрлэгээ хийхэд тусалж байгаа нь.

Онцгой нөхцөл байдалд хариу үзүүлэх

Турк улс 2023 онд болсон хүчтэй газар хөдлөлтөөс үүдсэн хохирлыг нөхөн сэргээсээр байна. Сүм тус улсын бүс нутгуудыг сэргээн босгох ажилд бусад байгууллагатай хамтран оролцож, сургуулиудыг сэргээн барих болон цэвэр усны систем суурилуулах төслүүдийг хэрэгжүүлжээ.

Украин дахь зөрчилдөөн ихээхэн хямралд хүргэж, улмаар 2024 онд тус бүс нутагт 55 хүмүүнлэгийн төсөл хэрэгжив. Эдгээрийн нэг нь КЭЙР (CARE)-тэй хамтарсан төсөл байсан ба Сүмийн санхүүжилтээр Украинд буй хүмүүст ариун цэврийн иж бүрдэл, гэр ахуйн хүнсний бус бараа материал, өвлийн иж бүрдэл мөн холимог эрчим хүч нөөцлөх систем олгосон байна. Орос улсад Сүм үерт нэрвэгдэгчдэд туслах төслүүдийг санхүүжүүлж, тусламж хэрэгтэй хүмүүсийг нэн чухал зүйлээр хангав.

Хүн амын эмзэг бүлэгт туслах

Хөүп (HOPE) төсөлд зориулсан Сүмийн хандиваар Молдав дахь дүрвэсэн хүмүүс, түүний дотор эмэгтэйчүүд, өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлжээ. Сүмээс Европ даяар Грек,

Норвеги, Бүгд Найрамдах Чех Улс зэрэг улс орнуудын эмзэг бүлгийн иргэдэд хүнсний багц, эрүүл ахуйн иж бүрдэл хандивлажээ.

Хүнсний аюулгүй байдал

Украин дахь яаралтай хүнсний хэрэгцээнд зориулж, хүмүүсийг нэг жилийн турш хооллоход хангалттай хүнсээр хангах Дэлхийн хүнсний хөтөлбөрт Сүм тусалжээ. Сүм бас Босниа дахь хүмүүст бие даах чадвартай болоход нь туслахын тулд Муслим Эйд (Muslim Aid)-тэй хамтран ажилласаар байна. Энэхүү хамтын ажиллагаагаар дамжуулан хувь хүмүүст өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээх боломж олгож, хүлэмж, зөгийн үүр, хээлтэй үнээ зэргийг олгожээ.

Турк дэх хүүхдийн бойтог

Герман дахь Халамжийн нийгэмлэгийн эгч Эрика бол тусламж хэрэгтэй хүмүүст хэрхэн үйлчлэх талаар гайхалтай үлгэр жишээг үзүүлдэг хүн юм. Тэрээр байнга гэр бүл, найз нөхдөдөө зориулан хүүхдийн бойтог нэхдэг бөгөөд Христийн мэндэлсний баярын амралтаараа Туркт тусламж хэрэгтэй шинэ гэр бүлүүдэд өгөхөөр 50 орчим хос бойтог нэхэхээр шийджээ.

Туркийн Антакия дахь дүрвэгчдийн хуаранд байрлах нэгэн хос мөн бүс нутаг даяарх зөөврийн эмнэлгүүдэд байрлаж буй бусад хүн бойтгийг аваад ихэд баярлажээ. Энэхүү жижигхэн бөгөөд энгийн хандивыг хүлээн авсан бүх хүн Эрикагийн сайхан сэтгэлд талархаж, Бурханы хайрыг мэдэрсэн билээ.

Би юу хийж чадах вэ?

- Тусламж хэрэгтэй хүмүүст зориулан хоол хүнс, эрүүл ахуйн иж бүрдэл хандивла.
- Европ дахь тусламж хэрэгтэй хүмүүсийг дэмжих төслүүдийг JustServe.org-ooc хайж ол.
- Орон нутгийнхаа хүнсний хангамжийн төвд сайн дураараа тусал.



Ойрх Дорнод

2024 онд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Ойрх Дорнод даяарх хэрэгцээг шийдвэрлэхийн тулд Ливан, Судан, Йемен зэрэг газруудад эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, орон байрны чухал төслүүдэд дэмжлэг үзүүлсэн. Түүнээс гадна Сүм Газ болон Израил дахь олон улсын тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дүрвэгчдэд эмнэлгийн болон сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлж, хоол хүнс, ус, эрүүл ахуйн хэрэгслээр хангасан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

2024 оны эхээр Сүм Йорданы Ал Хуссэйн нийгэмлэгт мянга гаруй тэргэнцэр, түүний дотор хүүхдийн 300 тусгай тэргэнцэр хандивлажээ. Энэхүү хандивын тусламжтайгаар Ал Хуссэйн нийгэмлэг эцэг эхчүүдэд тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах, арчилж тордохыг зааж сурган, хүүхдүүдэд шинэ эрх чөлөө олгосон аж.

Пакистан болон Йеменд Сүмийн хандиваар НҮБ-ийн хүүхдийн сан болон бусад байгууллагад дэмжлэг үзүүлж, жил бүр олон мянган хүний амийг авч оддог эх, нярайн татран (MNT) өвчний вакцинжуулалтыг нэмэгдүүлэхэд тусалсан байна. Түүнчлэн Сүм Бэйрутэд нүдний эмнэлгийг дахин нээх ажлыг санхүүжүүлж, тусламж хэрэгтэй хүмүүст хараа бэлэглэжээ.

Түүнээс гадна Сүм болон Курдистаны засгийн газрын хамтын ажиллагаа, тус төвийн захирлын алсын харааны ачаар Курдистан дахь Сувилагч, эх баригчдын хөгжлийн төвийг 2024 оны 1-р сард албан ёсоор нээв. Тус төв нь жилд 7,000 хүртэлх сувилагч, эх баригчийг сургаж, тэднийг нярай хүүхдүүдэд амьд үлдэхэд туслахад нь илүү сайн бэлтгэж өгөх болно.

Хүн амын эмзэг бүлэгт зориулсан дэмжлэг

Олон мянган хүн гэр орноо орхин, өөр хаа нэгтээ толгой хоргодох газар олохоос өөр аргагүйд хүрч байгаа бөгөөд Йемен, Сири, Ливан дахь эмэгтэйчүүд, хүүхдүүд үүнд бүр ч ихээр нэрвэгдэж байна. Сүм тусламжийн хөтөлбөрүүдэд хандив өргөн, дүрвэгчдийг хүчирхэгжүүлэх санаачилгуудыг дэмжиж, тэдний зовлонг нимгэлэхийг эрэлхийлдэг.

Жишээлбэл: Сүм Йорданд сүүний чиглэлийн хонины ферм байгуулахаар Ал Жяхут (Al Jahuth) байгууллагад 150 хонь хандивлажээ. Энэ ферм нь орон нутгийн иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд сургаж, шилжин суурьших хуаранд буй дүрвэгчдийг дэмжихийн тулд орлого олдог. Сүм бас Ливан дахь Рахма Ворлдвайд (Rahma WorldWide),



Ал Хуссэйн нийгэмлэгт хүүхдүүдийг шинэ тусгай тэргэнцэрт суулгаж байгаа нь.

Египет дэх Копт Үнэн алдартны сүм болон бусад байгууллагатай хамтран эмзэг бүлгийн иргэдэд яаралтай хүнсний тусламж үзүүлжээ.

Эрүүл, аюулгүй жирэмслэлтийг дэмжих нь

Йеменд амьдардаг Арвэйн жирэмсэн болсноо мэдээд санаа нь зовжээ. “Миний амьдардаг газарт анхны хүүхдээ төрүүлэх үедээ алдсан нэг эмэгтэй байдаг . . . Орон нутгийн эх баригч түүнийг төрөх үед бохирдсон багаж хэрэгсэл хэрэглэсэн учраас тэд хүүхдээ алдсан” гэж тэр хэллээ.

Сүм эмэгтэйчүүд, хүүхдүүдийг халамжлах ажлынхаа хүрээнд Арвэйн шиг эмэгтэйчүүдийг аюулгүй, эрүүл амаржихад нь туслахын тулд дархлаажуулалтын ажилд НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран. Энэхүү хамтын ажиллагааны ачаар тэр татрангийн вакцин хийлгэж, бяцхан хүү нь эрүүл, эсэн мэнд төржээ.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутагтаа байгаа дүрвэгчдэд тусалдаг шилжин суурьших төвд сайн дураараа ажилла.
- Орон нутгийнхаа эрүүл мэндийн хэрэгцээний талаар болон хэрхэн тусалж болох талаар илүү ихийг мэдэж ав.
- Бие даах чадвар хөгжүүлэх ангид хамрагдан, сурч мэдсэн зүйлээ ойр тойрныхонтойгоо хуваалц.





Юта мужийн ганц бие залуучууд Сүм болон Дэлхийн хүнсний хөтөлбөр хамтран ажилласны 10 жилийн ойг тохиолдуулан хүнсний хайрцгуудыг баглаж байгаа нь.

Хойд Америк

Сүм Америкийн Нэгдсэн Улс, Канад, Мексик даяар орон байр, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах олон тооны хүмүүнлэгийн ажилд оролцжээ.

Хүн амын эмзэг бүлэг

Бид Их Эзэний “Харь хүн байхад минь урьж оруулсан” (Матай 25:35) хэмээх үгэнд урамшин, гэр орон, орон байраа алдсан хүмүүсийг халамжлахыг хичээдэг. Үүнтэй уялдуулан Сүм хоргодох газар хайж байгаа хүмүүсийг боломжийн орон байраар хангахад туслан Хэйвен фор Хөүп (Haven for Hope), Сэйнт Лүигийн олон улсын институт, Сэйф Харбор (Safe Harbor) хямралын төв зэрэг олон байгууллагад бараа бүтээгдэхүүн болон мөнгө хандивласан юм.

Солт Лэйк Ситид жил бүр зохиогддог ганц бие залуучуудын хоёр дахь удаагийн чуулганд оролцогчид гурван өдрийн турш нэлээд хэдэн үйлчлэлийн төсөлд хувь нэмрээ оруулжээ. Тэд орон гэргүй хүмүүст зориулан хөнжил оёж, сэтгэл зүйн тусламжийн иж бүрдэл баглаж, орон нутгийн үйлчлэлийн төслүүдэд тусалж, тусламж хэрэгтэй хүүхдүүдэд хоол бэлтгэсэн байна.

Флоридад болсон аймшигт хар салхины улмаас олон оршин суугч зайлшгүй хэрэгцээт зүйлсээр гачигдаж, гамшгийн дараах цэвэрлэгээ хийх хэрэгтэй болсон байлаа. Сүмийн 21,000 гаруй гишүүн цугларч, АНУ-ын зүүн өмнөд хэсэг дэх 10,300 айл өрхөд тусалж, нийтдээ 311,000 цагийг сайн дурын ажилд зориулжээ. Сүм түүнчлэн зайлшгүй хэрэгцээтэй газруудад машин машинаар нь ус, хоол хүнс, эрүүл ахуйн иж бүрдэл болон бусад шаардлагатай зүйлийг илгээсэн байна.

Хүнсний аюулгүй байдал

Есүс дагалдагчдаа Өөрийнх нь хоньдын сүнс болон бие аль алиныг нь тэжээхийг зарлигласан. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бишопын агуулахууд болон хүнсний хангамжийн хандиваар дамжуулан, мөн Дэлхийн хүнсний хөтөлбөр (ДХХ) зэрэг хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн байгууллагуудтай хамтран ажиллаж, Хойд Америк даяарх эмзэг бүлгийн иргэдэд хоол хүнс олгоход тусалдаг билээ.

2024 онд Сүм болон Дэлхийн хүнсний хөтөлбөр хамтран ажилласны 10 жилийн ойгоо тэмдэглэн, тус хоёр байгууллага Юта дахь хэдэн зуун залуучуудын хамт муж даяарх хүнсний агуулахад зориулан 4,300 гаруй хүнсний хайрцаг бэлтгэжээ.

Канадад Сүм Дэйли Брэд хандивын хүнс (Daily Bread Food Bank)-д хандив өргөснөөр амьдралын өртөг өсөн нэмэгдэж байгаа асуудлыг даван туулахад нь Торонто хотын иргэдэд тусалдаг ажээ. Хойд Америк даяарх бие даах чадварт төвлөрсөн хөтөлбөрүүд нь тусламж хэрэгтэй хүмүүсийг богино болон урт хугацааны тусламжаар хангахын тулд хүнсний аюулгүй байдлыг дэмжин ажиллаж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж дэлхий даяар тэгш бус байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн дутмаг байдал хүмүүсийн амьдралд урт удаан, байнгын нөлөө үзүүлж болдог. Аврагч өвдсөнийг эдгээхэд амьдралынхаа ихээхэн хэсгийг зориулсан шиг Сүм хүмүүсийн амьдралын чанарыг материаллаг болон сүнслэг байдлын хувьд аль алинаар нь сайжруулахын тулд эмчилгээ үйлчилгээний ялгааг багасгахад туслахыг зорьдог.



“Бидний [хамтын ажиллагаа] удаан үргэлжилдгийн шалтгаан нь бидэнд хүнлэг сэтгэл, үйлчлэх дуудлага, итгэлцэл төрүүлэх зэрэг олон нийтлэг үнэт зүйл байдаг явдал юм.”

—КЛИФФ ХОЛЦ, АМЕРИКИЙН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ¹⁸

Өмнөд Мексиكت тусламж хэрэгтэй олон нийт, хувь хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд төвлөрч байна. Вэракрузын хөдөө тосгоны өвчтөнүүдэд шаардлагатай тусламж үзүүлэх зорилгоор чихрийн шижингийн теле-анагаах ухааны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд Сүм Мексикийн Улаан Загалмайн нийгэмлэгтэй хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжгүй хүмүүст илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийг нь шинэчилж өгчээ.

Түүнээс гадна, Сүмийн хандиваар Католик тусламжийн үйлчлэл (Catholic Relief Services) болон Мексикийн Адвэнтист Хөгжлийн болон Халамжийн Агентлагийн орон нутгаар дамжин цагаачилж буй эмзэг бүлгийн хүмүүст орон байр, эм тариа, эмнэлгийн тусламж үзүүлэхэд нь тусалжээ. Эдгээрийн дотор эмэгтэйчүүд, хүүхдүүд нэн эмзэг бүлэгт тооцогддог бөгөөд эрүүл мэндийн дэмжлэг нь хоол тэжээлийн дутагдал болон бусад урьдчилан сэргийлж болох өвчнүүдээс хамгаалахад тусална.

Би юу хийж чадах вэ?

- Орон нутгийнхаа хүнсний агуулахад бараа бүтээгдэхүүн хандивла эсвэл сайн дурын ажилд цаг гарга.
- Гэр орон, оршин суугаа газартаа онцгой байдлын бэлтгэлийн төлөвлөгөө гарга.
- Орон нутагтаа байгаа дүрвэсэн хүмүүстэй харилцаа холбоо тогтоож, тэднийг дэмжих арга замуудыг бодож үз.



Охайогийн өсвөр үеийнхэн олон нийтийн үйлчлэлийн төсөлд оролцож байгаа нь.

Гай зовлонгийн дараа итгэл найдварыг олсон нь

Тэксас дахь нэгэн гэр бүлийн хос Хюү, Марта* хоёр Тэксасын түүхэн дэх хамгийн том түймэрт мал амьтныхаа гуравны нэгийг алджээ. Түймрийн улмаас мал сүргийнх нь бэлчээрийн газар сүйдэж, сүрэгт нь идэх юм бараг үгүй болсон байв.

Түймрийн дараа Сүмийн бишопуудын төв агуулахууд Хюү, Марта зэрэг бүс нутгийн фермерүүдэд олон боодол өвс илгээжээ. Ийм хүнд үед гэр бүлээ тэжээхийн тулд үлдсэн хөрөнгөө зарахын оронд тэд малаа тэжээж, эдлэн газраа үргэлжлүүлэн ажиллуулж чадсан юм.

*Нэрийг өөрчлөв



Талархал

Бид дэлхийн өнцөг булан бүрд буй Бурханы бүх хүүхдийг халамжлах ажилд оролцсон Сүмийн гишүүд болон найз нөхөд та бүхэнд талархлаа илэрхийлж байна. Та бүхний зориулсан цаг зав, мөнгө, авьяас чадварыг үнэлж, агуу өөрчлөлт авчирсанд тань талархаж байна.

Бид мөн хүмүүнлэгийн ажлын цар хүрээгээ өргөжүүлэхийн тулд ашгийн бус байгууллагуудтай хамтран ажилладагтаа баяртай байна. Бид ирэх жилүүдэд эдгээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг тэсэн ядан хүлээж байгаа бөгөөд ирээдүйд хамтдаа ямар амжилтад хүрэх вэ гэдэгт догдолж байна.

Бурхан таны залбирлыг сонсдог бөгөөд тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжилдгийг тань мэднэ. Үйлчлэл тань таны амьдралыг амар амгалан, итгэл найдвар, хайраар адисалсан гэдэгт бид найдаж байна. Бид та бүхнийг Бурханд болон бие биедээ хайраа үргэлжлүүлэн үзүүлэхэд урьж байна.



Сүмийн халамж үйлчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Caring.ChurchofJesusChrist.org-оо авна уу.



Кодыг уншуулж JustServe аппликэйшныг татаж аваад, харьяа газрынхаа сайн үйлсийн аянд оролцоорой.

Илүү ихийг мэдэхийн тулд цахимаар зочилно уу

- ◆ ChurchofJesusChrist.org
- ◆ Caring.ChurchofJesusChrist.org
- ◆ JustServe.org
- ◆ DeseretIndustries.org
- ◆ AddictionRecovery.ChurchofJesusChrist.org

Нэмэлт эх сурвалж

Инстаграм

- ◆ @Caring.ChurchofJesusChrist
- ◆ @Deseret_Industries
- ◆ @JustServe

Фэйсбүүк

- ◆ @Caring.ChurchofJesusChrist
- ◆ @DeseretIndustriesThrift
- ◆ @JustServe.org



Эх сурвалж

1. "Ядуус болон гачигдагсдад туслах," *Лиахона*, 2022 оны 11-р сар, 6.
2. Sarah Bouchie, in "Relief Society Leads Global Effort to Improve Health and Well-being of Women and Children," Newsroom, June 12, 2024, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/relief-society-global-effort-health-well-being-women-children>.
3. Instagram, June 1, 2024, https://www.instagram.com/p/C7rkEN9Mdn6/?img_index=1.
4. "Та нарын баяр хөөр хэчнээн агуу байх билээ," *Лиахона*, 2023 оны 11-р сар, 58.
5. Gérald Caussé, in "Why Is Utah Thriving? Look to Latter-day Saint Pioneer Values, Presiding Bishop Says," Newsroom, May 22, 2024, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/latter-day-saint-pioneer-values-utah-presiding-bishop>.
6. "Баатраас илүү," *Лиахона*, 2023 оны 11-р сар, 89.
7. Даллин Х.Өүкс, "Ядуус болон гачигдагсдад туслах," *Лиахона*, 2022 оны 11-р сар, 6.
8. Gérald Caussé, in "Bishop Caussé shares 4 pioneer values that contribute to success in worldwide stewardship," The Church News, May 22, 2024, <https://www.thechurchnews.com/leaders/2024/05/22/bishop-gerald-causse-shares-4-pioneer-values-in-worldwide-stewardship/>.
9. L. Todd Budge, in "There's No Greater Blessing Than to Be an Instrument in God's Hand,' Bishop Budge Tells Missionaries," Newsroom, Nov. 29, 2023, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/-there-s-no-greater-blessing-than-to-be-an-instrument-in-god-s-hand-bishop-budge-tells-provo-mtc-missionaries>.
10. Patrick Kearon, in "Latter-day Saints and Environment," Newsroom, Nov. 6, 2023, <https://news-middleeast.churchofjesuschrist.org/article/kearon-latter-day-saints-and-environment>.
11. Camille N. Johnson, in "The Church's efforts to improve nutrition for women and children, one by one," *Church News*, Mar. 16, 2024, <https://www.thechurchnews.com/living-faith/2024/03/16/global-nutrition-efforts-women-and-children-well-being-relief-society/>.
12. Barron Segar, in "Building self-reliance and feeding the hungry in Liberia," *Church News*, Jan. 25, 2024, <https://www.thechurchnews.com/global/2024/1/25/24048234/church-building-self-reliance-feeding-the-hungry-in-liberia/>.
13. J. Anette Dennis, in "Sister J. Anette Dennis: Trust That the Lord 'Will Meet You Where You Are,'" Newsroom, June 22, 2022, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/sister-j-anette-dennis-trust-that-the-lord-will-meet-you-were-you-are>.
14. Solomon Akpanufot, in "Church of Jesus Christ Celebrates 'World Water Day' With Donation to Mboshi Aji Community in Nigeria," Newsroom, Mar. 31, 2024, <https://news-africa.churchofjesuschrist.org/article/church-of-jesus-christ-celebrates--lquo-world-water-day-rsquo--with-donation-to-mboshi-aji-community-in-nigeria>.
15. HE Nhek Ban Kheng, in "Church collaborates on new hospital in Cambodia and renovations to 3 more," *Church News*, Mar. 16, 2024, <https://www.thechurchnews.com/living-faith/2024/03/16/cambodia-health-improvement-effort-church-collaborates-new-hospital-renovations>.
16. Kristin M. Yee, in "Relief Society General Presidency: How Jesus Christ Offers Spiritual and Temporal Relief," Newsroom, July 5, 2023, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/relief-society-general-presidency-how-jesus-christ-offers-spiritual-temporal-relief?lang=eng>.
17. "Бидэнд хайр байдаг юм," *Лиахона*, 2023 оны 11-р сар, 111.
18. Cliff Holtz, in "The Church of Jesus Christ Contributes US\$7.35 Million to the American Red Cross," Newsroom, Mar. 21, 2024, <https://newsroom.churchofjesuschrist.org/article/church-jesus-christ-american-red-cross-2024-donation>.



